

Jai Shri Mataji Nirmala Devi!

Translations - Mongolian 2024-0501

1980-0608, Talk to Sahaja Yogis, Subtlety (part)	3
1981-1029, Practical session, Guided meditation on Prana and Mana (part)	4
1982-0818, Shri Mataji Working On New People (part)	6
1983-0129, Public Program, False Gurus and Conditionings (part)	9
1987-1025, Diwali Puja, Power of Innocence (part)	15
1988-0110, Makar Sankranti/Shri Surya Puja (part)	17
1988-0618, Seminar Day 1, Introspection and Meditation	19
2000-0916, Shri Ganesha Puja (part)	25
2002-1103, Diwali Puja, The Importance of Meditation (part)	28

1980-0608, Talk to Sahaja Yogis, Subtlety (part)

[View online.](#)

Talk to Sahaja Yogis, Subtlety (part)

Та Бурхан мөн үү? гэж Павел асуухад хариулсан талаар Надаа таныг Бурхан гэсэн, Бурхан өөрөө байгаа юм, гэж хэлсэн. Үүнд л хариу хүссэн юм. За. Одоо, над руу гараа хандуулаад өөрийн асуултаа тавь. Компьютер шиг амархан (хариулт чинь ирнэ). Компьютероо ажиллуул. Асуултаа тавь. Гүйцээ. Тэр бол "И" юм. Тэр бол Агуа Бурхны хүсэл юм. Тэр бол Бурхны хүч нь юм. Зөвхөн тэр л хувилгаалж төрдөг. "Веда" судрыг уншсан бол, Тэр (Эх) өөрөөсөө хүү төрүүлсэн гэж байдаг. Тэгээд анхны бүтээгдсэн дуу авиа бол (ОМ) хүүхэд байсан. Тэр авиа нь бол бидний, Брахма (Оюун) Логос гэж (баруунд) хэлдэг авиа байгаа юм. Тэгэхлээр одоо, Бурхан болон Бурхны хүсэл хооронд ямар ялгаа байх уу? Нар болон нарны гэрэл хооронд ямар ялгаа байх билээ? Сар болон сарны туяа хооронд ямар ялгаа байх билээ? Үг болон үгний утга хооронд ямар ялгаа байх билээ? Тэгэхлээр, Агуу Бурхан нь хүн ойлговол, зөвхөн (бүхнийг харж байдаг) "ГЭРЧ" юм. (Эр/Эм, Эцэг/Эх гэх) Энэ хоёр зүйл хоорондоо уусан нэгдэх тэр өдөр энэ ертөнцөөс юу ч үлдэхгүй. Салангад байгаа учир л эдгээр (ертөнцийн) зүйлс болж байгаа/байдаг. Тэр хоёр уулзаад, уусан нэгдвэл юу ч үлдэхгүй. Энэ нь Брахма (Оюуны) авиа л болон хувирна. Үүнийг хүн хэзээ ч ойлгохгүй. Яагаад гэвэл энэ хоёр, -Бурхан болон Түүний хүч нь- тэгж уусан нэгдэх талаар хүн огт мэдэхгүй. Хүн ойлгохгүй. Ямар ч тийм зүйлийг. Яагаад гэвэл үүнийг харьцуулан ойлгуулах ямар ч зүйл байхгүй учир. Яахав, хүн зүйлсийг мөн бодлоороо ойлгож болно. Жишээ нь, хүмүүс надаа мэхийвэл, тэдний Кундалини нь сэргэж эхэлдэг. Энэ нь сударт бичээстэй байдаг, зөвхөн Ади Шакти-н өлмийд л ийм зүйл болно гэсэн байдаг. Зөвхөн энэ ч биш, та бүхэн хатуу горим гэх мэт хэцүү горимыг амьдралдаа мөрдөөгүй ч, дотоод Оюунаа сэргээлгүүлсэн. Тэгээд таны өөрийн Оюуны хүч чинь бусдын Оюуныг идэвхжүүлэх хүчтэй болж. Энэ дэлхий дээр өөр тийм хэн ч байхгүй, өнөөгийн байдлаар. Магадгүй, зарим гэгээнтнүүд, та нар шиг, Оюуныг идэвхжүүлэх чадвартай байж магад. Тэр агуу Гуру багш нар дээр очоод уулз. Тэд та бүхэнд атаархадаг. Тэд намайг хэн гэдгийг мэддэг. Мөн хүмүүст намайг хэн гэдгийг хэлдэг. Гэхдээ тэд атаархадаг. Яагаад та нар шиг хүмүүст бүх хүчийг олгоод буйг тэд ойлгодоггүй. Тэдэнд энэ нь байдаггүй. Тэд, та нар шиг Оюуныг сэргээж чаддаггүй. Хэн нь ч чадахгүй. Та нар очоод харж болно. Тэд агуу хүмүүс. Гарцаагүй. Гэхдээ та нарын Кундалини бол пуужин шиг л ажилладаг. Харин тэд бол заан шиг (удаан) хөдөлж байна. Нэг хүрднээс нөгөө хүрд рүү. Тэдний Кундалини нь та нар шиг тэгж урсдаггүй, яагаад гэвэл би та бүхэнд тэр эрхийг нь өгсөн учир. Та бүхэн тэр гэгээнтнүүдтэй очоод уулз, тэд танд хэлнэ. Мянга мянгаан шавь нартай байдаг. Гэхдээ тэднийгээ тэд над руу явуулдаггүй. "Та чанартай хүмүүсээ ол", гэдэг "Эдгээр бүдүүн болхи хүмүүсийг нь бидэнд орхичих" гэдэг. "Эднийг бид дараа нь тана руу явуулья. Одоо та өөрийн нарийн хүмүүсээ ол", гэдэг Яагаад Сахажа йогчид ийм цөөхөн бгаа юм? Яагаад гэвэл энэ дэлхийд сайн чанарын, нарийн хүмүүс маш цөөн. Тийм учраас би ямагт та бүхнээс, анхаарлаа энд тэнд (алдаж) сарниулж хэрэггүй гэдэг. Буурьтай, сайн сахажа йогчид бол. Та бүхэн үнэхээр сайн сахажа йогч болохоос нааш би дараахь түвшин рүү (та бүхнийг аваад) шилжиж чадахгүй байна. Учир нь эхний түвшин нь тогтоогүй учир. Утгагүй зүйлд тэд санаа зовж байдаг учир. Заримдаа би маш гунихарладаг та бүхнийг хоорондоо тэмцэлдэхийг хараад. Энэ чинь сэтгэл өвдмөөр юм. Хоорондоо ширүүн ярьж байдаг. Та бүхэн миний хувьд тосны дээж нь шүү дээ. Та нар яваад ямар ч багшаас асуу. Кундалини хүчийг та нар шиг тэгж гараараа хөдөлгөн сэргээж чадах уу? гээд асуу. Эдгээр хүчийг энгийн хүн сэргээж өгч чадахгүй шүү дээ. Би энгийн харагддаг. Гарцаагүй. Би тийм (энгийн) байх ёстой юм. Гэхдээ та бүхэн намайг бусад хэлбэрээр минь мөн харсан. Энэ чухал биш. Чухал зүйл бол, өөрсдийн дэвшлийг олж харах. Хэр их, ямар хүчнүүд нь танд илэрч байна, энэ нь чухал. Хэрвээ та хүнд, би хүний Оюуныг идэвхжүүлж эхэлсэн, Кундалини-г нь өргөж чаддаг гэвэл тэд, "Солиотой юм уу, боломжгүй зүйл шүү дээ" л гэнэ. Хэн ч танд огт итгэхгүй. Үнэндээ, та бүхэн үүнийг маш хялбар олсон. Яагаад? Яагаад гэвэл би та бүхний гүнзгий нарийныг олж мэдсэн учир. Тэр гэгээрсэн багш нар намайг мэддэг, хэн гэдгийг минь таньдаг. Мөн хүмүүст хэлдэг. Тийм, маш олон хүн байдаг. Би та бүхэнд нэг Америк эмэгтэйн талаар ярьсан. Тэр ирэх байх. Та бүхэн түүнтэй уулзсан биздээ? Зарим чинь түүнтэй уулзсан. Тэр Рангол очоод тэнд маш агуу, өндөр түвшний гэгээнтэнтэй уулзах гэж очиж. Тэр гэгээнтэн ууланд амьдардаг. Олон хүн хүлээж авдаггүй хүн байсан, гэхдээ тэр тийшээ очиж. Гэтэл тэр гэгээнтэн багш тэр эмэгтэйг үнэндээ хүлээж байж. Тэгээд дотогш ортол: "би танаас доор сууя" гэж. Тэр эмэгтэйг учирьг нь ойлгохгүй гайхаж гэнэ. Тэр:"Яагаад гэвэл та Эхийг өөрийн нүдээр харсан учир. Би бол хараагүй" "Би харин Эхийг харахын тулд үхэх хэрэгтэй болох байх" гэж.

1981-1029, Practical session, Guided meditation on Prana and Mana (part)

[View online.](#)

Practical session with Sahaja yogis, Bramham Court Ashram, London, UK, 29th October 1981.

Бидэнд "Прана" мөн "Мана" байдаг "Прана" нь баруун сувгийн төлөөлдөг "Мана шакти" нь зүүн тал. "Прана" нь баруун сувгийн төлөөлдөг "Мана шакти" нь зүүн тал. Энэ хоёр хүчийг хооронд нь уусгах хэрэгтэй. "Лаяа" болгох - уусгах гэж байгаа. Үүнийг яаж хийх вэ? Энэ хоёрыг яаж уусгах вэ? (Бид үүнтэй нь холбоотой байдаг) Зулай нь нээгдсэний дараа (энэ боломжтой). Өмнө нь биш. Бясалгахаас өмнө бид өөрсдийгөө тэнцвэржүүлэх хэрэгтэй. Аль тал нь их. Аль тал нь бага байна? Жишээ нь, тухайн үед сэтгэлээр унасан бол Аль тал нь их. Аль тал нь бага байна? Жишээ нь, тухайн үед сэтгэлээр унасан бол баруун энергийг нь зүүн тал руу нь оруул. Зүүн талдаа муудсан байвал, баруун энергийг нь зүүн тал руу нь оруул. Зүүн талдаа муудсан байвал, Зүүн суваг нь царцсан, хөлдсөн бол зүүн сувгаа өргөж, сэргээ. Бясалгахаасаа өмнө өөрийгөө төв тэнцвэрт нь оруулах хэрэгтэй. За, өөрсдийгөө харъя. Аль тал нь дутуу байна, эхлээд харъяа. Гараа ингээд барь. Зүгээр байна уу? Сэрүүн энерги байна уу? Сэрүүн энерги байна уу? Энэ гарт нь байна уу? (За.) Дээрдсэн үү? Энэ гарт нь энерги байна уу? Одоо? Ямар нэг юм урсаж байна уу? Сэрүүн урсгал одоо байна уу? Сэрүүн энерги байна уу? Байна уу? Гарт нь сэрүүн салхилж байна уу? Мэдэрч байна уу? За, зүгээр. Тэгэхлээр, өөрийгөө төв, тэнцвэрт оруулсныхаа дараа өөрийн сэтгэл хөдлөл (манас шакти)-руу анхаарлаа хандуулсан нь дээр. Анзаараад хар. Өөрийн 'Эх'-ийг бодоод, сэтгэлээ гэгээрүүлж болно. Ойлгов уу? түүнийгээ гэгээрүүлэхийн тулд... 'Эх' нь, асуудлыг нь шийднэ. Мана (сэтгэлд)-д байгаа аливаа асуудлыг (Эх нь) шийддэг. 'Эх' нь, асуудлыг нь шийднэ. Мана (сэтгэлд)-д байгаа аливаа асуудлыг (Эх нь) шийддэг. Тэгээд та өөрийн сэтгэлтэй холбогдоод ирвэл бясалгахдаа сэтгэлээ анзаараад эхэлвэл тэр сэтгэлийн урсгал чинь өгсөөд ирэхийг харна. Дотроо. Тэгээд хэрвээ та тэр сэтгэлээ өөрийн "мана" руу - 'Эх'-ийн өлмийд уусгахын хичээвэл тэр сэтгэл чинь мөн уусан хайлж эхлэнэ, тэгээд тэр сэтгэл чинь тэлэн ужирна. Тэлэн тархна. Нээгдэнэ. Тэр сэтгэл чинь тэлэж, та өөрөө үүнийг хянах боломжтойг нь мэдрэнэ. Сэтгэлийн хувирлаа өөрийн мэдэлд оруулна. Улмаар, таны уужирч, гэгээрсэн сэтгэл чинь маш хүчтэй. Тэгээд энэ сэтгэлээ та тэгж өөрөө анзаарч мэдэрч чадвал тэр сэтгэлийг хүндрүүлэх асуудал шалтгаанууд шийдэгдэн арилдаг. Жишээ нь саяхан, би хүүхдийн хүндрэлийг ярьснаас болоод та нар сэтгэлээр унасан Мэдээж хэрэг, хэн ч тэгнэ. Та хэрвээ сэтгэлээр унасан бол тэр сэтгэлд мэдрэгдэх тэр хүндрэлийг тэр давалгаалах асуудлыг нь өөрийн 'Эх'-ийн өлмийд даатган уусга. Улмаар, тэдгээр нь тэр хүчинд хүрнэ тэгээд тэр сэтгэл нь - уусан гэгээрнэ. Тэгээд тэр сэтгэл нь - уусан гэгээрэхээр аливаа асуудлыг шийдэх чадвартай болдог. Ойлгосон уу? Гэрлийн эрэгт хүрээд гэрэлтэй болоод аливаа асуудал шийдэгддэг байгаа. Учир нь, одоо та бүхэн тусдаа, салангад нэгж биш та бүхэн "самашти" буюу ДАЯАР огторгуйд орсон Энэ оюуны оршихуй руу нэвтэрсэн учир, та бүхэн бусдын бие рүү нэвтрэх тийм чадвартай бусдын энерги долгионыг мэдрэх, бусдын Кундалиниг нь сэргээх чадвартай болсон юм. Эс тэгвээс та чадахгүй байсан. Тиймээс, та бүхний хувьд энэ маш хялбар болсон. Яагаад гэвэл мөн "би" энд биеэрээ байгаа учир. Тэр сэтгэлээ тэнд нь аваачаад, улмаар тэр нь гэгээрч, хүслүүд чинь биелэх нь маш хялбар болсон. Учир нь, сэтгэл хөдлөл нь зүгээр хүслүүд юм. Сэтгэлийн хөдөлгөөн нь биелээгдээгүй хүслүүд юм. Өөрөөр бас яаж хийдэг вэ гэвэл... Эдгээр сэтгэл хөдлөлийг аваад тэнд нь оруулах... Тэгэхлээр, эдгээр сэтгэлийн хөдөлгөөн нь, үнэндээ, зүүн сувагт илэрдэг (би хэлж байсан) хүсэл мөрөөдөл байгаа юм. Тиймээс, ямар ч хүслийг аваад "прана" руу нь оруулна. "Прана" руу нь яаж оруулах билээ, гэвэл өөрийн "прана"-г хянаж. Тийм учраас "пранаяама" хийдэг байгаа юм. өөрийн "прана"-г хянаж. Тийм учраас "пранаяама" хийдэг байгаа юм. Жишээ нь, одоо суугаад, маш тав тухтай Та ямар нэгэн хүсэлтэй байгаа. Хүсэл рүү нь анхаарлаа хандуул. Анхаарал нь маш чухал. Одоо энэ анхаарлаа (сэтгэлтэй) нь "прана" руу оруулах ёстой. Сэтгэл (хөдлөл) нь байгаа тэдгээр сэтгэлийг нь анхааралдаа авна тэр сэтгэлийн байдлыг ухаарч мэдэрнэ гэсэн үг. ...тэгээд одоо өөрийн амьсгалаа анхаар... ..бүх зүйлийг зогсоохыг хичээ... амьсгалаа багасга... нэг үгээр, ...амьсгалаа гаргаад... хүлээ... Тэгээд амьсгалаа ав. Удаанаар... Тэгээд амьсгалаа гарга. Тиймээс, 1 минутанд, амьсгал чинь багасна. Хийгээд үз... Амьсгалаа ав... Анхаарлаа сэтгэл дээрээ барь. Холбоог тогтоохын тулд Дээр болов уу? Кундалини нь өгсөж байгааг харав уу? Амьсгалж байхад, хоёр амьсгалын хооронд зай байгаа, түүнийг нь уртасга. Амьсгалаа аваад хүлээ... Одоо амьсгалаа гарга... түгжээд хүлээ Амьсгалаа аваад, дотор нь байлга... тэгээд гарга... гадна нь байлга... Одоо амьсгалаа ав... Одоо амьсгалаа зогсоосон мэт амьсгал... Анхаарлаа - зүрхэндээ эсвэл сэтгэл дээрээ байлгаарай... Дээр болж Амьсгалаа аваад, хэсэгтээ дотроо байлга Амьсгалаа гаргаад, гадаа нь хэсэг байлга Тэгээд дахиад. Хэсэг хугацааны дараа амьсгал чинь өөрөө зогсоно. Харав уу? Намдаад ирнэ. "Лаяа" үүсч байгаа юм. "Прана", "Мана" 2-н чинь хооронд Хоёр

хүч уусан нэгдэж, 1 болж байгаа юм. Одоо энэ аниргүй болсон түвшиндээ харвал өөрийн тархины бодлуудыг хар байхгүй болчихсон. Зүгээр хар, тэнд нь байхгүй болчихсон. Юу болсон бэ, гэвэл энэ "Лаяа" нь анхаарал нь тархины бодлууд дээр очин, тархийг гэгээрүүлж байгаа юм. Харав уу, бодлууд байхгүй. Өөр дотроо бодлоо хайж олохыг хичээ. Миний бодлууд хаана байна? Бодлууд байхгүй. Үйлдэхгүй болчихсон. Дахиад үз. Энэ нь үйлдэж байгаа, гэхдээ "Самашти" болчихсон. Даяар Оюун болчихсон. Одоо харав уу? Дагаж хийсэн үү? Ямар ч бодол байхгүй. Энэ дасгал нь бодлоос ангид Оюун руу оруулна. Бодлоос ангид түвшинд тогтворжуулна. За, энэ бол 2-дахь хичээл. За. Бурхан та бүхнийг ивээх болтугай!

1982-0818, Shri Mataji Working On New People (part)

[View online.](#)

Workshop with new people. Nirmala Palace - Nightingale Lane Ashram, London (United Kingdom) 1982-08-18

Сууцгаа (йогчин юм асууна...) Тийм. ихэнхэд нь хэрэгтэй гэж бодно... Бага зэрэг. Сахажя йога-нд та бүхэнд тусгай тарни ноогдуулах тийм зүйл байхгүй том сургалт явуулж шат шатаар тарни өгөх зэрэг тийм зүйл байхгүй. Та бүхэн, Кундалини чинь хаана байна яаж хөдөлж байна, хаана байна, хүрд нь юунд гэмтэж бна, үүнд ямар тарни хэлэхийг сурна. Энэ тийм хэцүү биш. бүхэлдээ 7 хоногт л бүхнийг сураад, ойлгодог болно. Аажмаар, үүнийг ашиглаад ирвэл та туршлагатай болж өөртөө мөн бусдад үүнийг хэрхэн хэрэглэхээ мэддэг болно. Үүнд нэг их хэцүү зүйл байхгүй. Жишээ нь, хүүхэд, бага байхдаа хэлд орохдоо, цаанаасаа яриад эхэлдэг. Түүнд ярих өгөгдөл нь суулгаастай байдаг учир, тэгээд яриад эхэлдэг. Үүнтэй адил, нэг сурчихвал, гарандаа сэрүүн энергийн урсгалтай болвол та үүнийг өөрөө хэрэглээд, ойлгох болно. Өөрөө үүнийг ойлгоно. Та өөрөө дажгүй чадварлаг болно. Үүнийг ямар хурдан сурчихаа вэ, гээд та өөрөө ч гайхах болно. Сурах бичиг, ном судлаж суух шаардлагагүй. Зүгээр л мэддэг болно. Энэ хүрд нь сэвтлээ гээд... Жишээ нь, энэ хуруу сэвтэх нь мэдрэгдвэл Баруун талд. Үүнд нь тарни бий. Шри Кришна-гийн.. Жишээ нь, энэ хуруу мэдрэгдвэл Энд нь, Есус Христийн тарнийг хэлнэ. Ийм маягаар, та бүхэн тарниа мөн хүрдээ мэддэг байх хэрэгтэй. Та бүхэн хүрднүүдийг мэднэ, хүрднүүд нь туйлын үнэмлэхгүй мэдлэг агуулдаг, та бүхний мэдрэлд суулгаастай байдаг. Үүнийг та өөрөө мэдрэнэ. Энэ хүн энд халуун мэдрэгдээд байна гэсэн. Энэ юу гэсэн үг вэ? Энэ халуун нь юу гэж байгаа юм? Сахасрара нь зүүн талд... Эхлээд баруун талд Сахасрара нь м. байсан Одоо энд, зүүн талд байна. Үүнд нь, тарни бий... Үүнийг нь хэрэглэх хэрэгтэй. Хэрвээ хэргэлвэл энэ нь засрагдан ариусна. За юу? Ийм маягаар, ингэж сурна. Тийм учир, зарим хүнд удаан тогтдог. Яагаад гэвэл эхлээд (энергийг нь) мэдэх хэрэгтэй. Дараа нь хэрэглэх боломжтой болно. Ор, ор. Та анх удаа ирж байна уу? за за... Ороод суу. Ийшээ ор. Тэгэхлээр, энэ хэцүү зүйл биш. Үүнийг нь сурахад хэцүү зүйл биш. Маш амархан. Маш хурдан сурчихна. Гараараа бусад дээр ажиллаад эхлэнгүүт... (Та суугаач...) Тэр хүмүүсийг оруулаадахъя Эдгээр хүмүүс, жишээ нь, Сахажя йогт хэн хамгийн сүүлд ирсэн бэ? хамгийн сүүлд ирсэн шинэ хүмүүс? Жишээ нь, ирээд ойролцоогоор сар болж байгаа хүн байна уу? Тэр эмэгтэй ирээд сар л болж байгаа.. Энэ хүн анх удаа ирсэн. 1-дэхэд ирсэн хэр удаан...? Аа тийм, энэ хүн 1-дэх өдөр ирсэн Энэ хүнд болсон байна. (Харин эмэгтэй рүү) Та хүрдэндээ энерги өгч байв уу? "Тийм ээ" Нэг сарын хугацаанд энерги нь бүрэлдэж. Төсөөлөлдөө, Та одоо хүрднүүдийн талаар мэдэх үү? Тарниудын талаар? "Мэднэ." Харав уу, ийм байна. Маш амархан. Үүнд анхаарлаа сайн хандуулвал, илүү хурдан сурна. Энд байгаа олон хүмүүс нэг сарын дотор маш их юм сурсан. Олон хүмүүс иймэрхүү байгаа. 1-хэн сард л.... Та бүхэн өөрсдөө мэдлэг болдог учир, өөрсдийн хуруунууд дээр мэдэрч эхлэнэ. Энэ/тэр хүрд байна гээд мэддэг болно. Хэрвээ энэ хуруу нь халуу шатвал таны зүүн зүрх чинь гэмтсэн гэсэн үг. Зүүн зүрх нь гэмтэлтэй бол шууд л мэднэ, халуун оргидог учир, Ном зэрэг уншиж хайж судлах хэрэггүй, зүгээр л халуун оргиод л, тодорхой. Тийм биз дээ... Энэ нь "зүүн" зүрх сэвтсэн гэсэн үг. Одоо харин яагаад сэвтсэн буйг л мэдэх хэрэгтэй. Кодыг нь тайлах. Энэ (мэдрэгдэх) нь юу гэсэн үг вэ? "Гар чинь ярих болно" гэж Христ хэлж байсан Гар нь мэдүүлээд, би зөвхөн кодыг нь тайлна. Мөн өөрсдөө үз. Үнэн бна уу, үгүй юу? Юу гэсэн үг вэ? Ол. "Зүүн" зүрх гэдэг нь зүрхэндээ асуудалтайг харуулна. Магадгүй, тухайн хүн хэт ачаалалтай ажилладаг, Амин Сүнсээ орхигдуулсан байх. Үүнд хэлэх тарни бол "Би Ариун Сүнс" гэж "зүүн" зүрхээ тэнхрүүлэх. Ийм хялбар. Амин Сүнсээ мартсан учир.. Баруун суваг руу илүү их ороод, илүү гадагшаа хандсан тул, анхаарал чинь илүү гаднаа, амьдралын зүйл рүү илүү хандсан учир. Амин Сүнсээ орхигдуулахаар, "зүүн" зүрх гэмтдэг. Энерги "долгион" чинь тогтвортой сайн болоод ирвэл, та бүхэн Сахажя йогийг маш сайн ойлгодог болно. Жишээ нь, энэ хуруу сэвтээд байвал, тухайн хүн сүнсний түвшинд ямар ч эрхгүй хуурамч багш дээр очсоны тэмдэг Юу ч байж болно, ESP, EST, парапсихологи, сэтгэл зүйч ч хүртэл байж болно, Тэгээд төрөл бүрийн багш нар байгаа, хуурамч багш нар мөн тэр Аура бизнесүүд Өөр юу байдаг билээ? Р. хэлж байсан? Ер бусын -Хэт дээгүүр, Хэт доогуур... Эдгээр бүх урсгалууд Таны мэдэх бүх урсгал хувилбарууд тэдний номнууд нь мөн лам нар, гэх мэт, бүгд... Мөн сүмд явах хэт их дуртай хүмүүс, эсвэл католизмд элэгтэй хүмүүс Яагаад гэвэл тэд Бурхантай холбоогүй учир тэд Бурхны зөвшөөрөлгүй, эрхгүй Харин, хэрвээ та жинхэнэ багш дээр очсон бол би шууд мэднэ. Танд эдгээр асуудал байхгүй байх байсан мөн та маш хурдан өгсөх байсан Гэхдээ үнэн багш хэд байна, өдгөө? Гадуур зөвхөн тэр наймаачид нь л байна Гүйлгэнд зөвхөн худалдан авагч, наймаалагч нар л байна Энэ нь худалдаа арилжааны салбар болж. Жинхэнэ багш нар нь гэтэл харагдадгүй. Мэдээж, тийм үнэн олон багш нар байдаг, би мэднэ. Тэд хаана ч байлаа, тэд гадуур ил байдаггүй. Би ганцаараа л, тэдэнтэй тэмцэн, тэдний эсрэг хэлж байдаг. Аль ч үнэн багш нараас, ийш бууж ирэхийг хүсдэггүй. Тэд:

"Хүмүүс найдваргүй", гэдэг Тэд: "Эх минь, та 12 жил ажиллаадах тэгээд бид бууж ирье" гэсэн. Тэд намайг ганцааранг минь тэмцэл дунд орхисон, зайлуул. Гэхдээ хамаагүй. Гэхдээ одоо энэ нь арилжааны салбар болж. Тэгээд худалдан авагч нар нь энгийн гэнэн хүмүүс. Тэр (хуурамч багш нар) маш утгагүй юм хийж байдаг. Жишээ нь: "би нэг юм зарах гэж байна" гэдэг. "Маш том орд харш, бүрэн хогшилтой нь...", "та зөвхөн 2 000 фунт стерлинг төлөөд л ав." гэдэг. Хүмүүс, "өө, дажгүй наймаа байна, 2 мянгыг нь төлөөд авья", гэдэг. Гэтэл, тэр зарах ордон нь хатан хааны эзэмшлийнх Тэднээс, "аль ордон юм?" гэж асуувал. "Энэ ордон" гээд (өөрсдийн биш) хатан хааны ордныг заана. Энэ нь зөвшөөрөлгүй үйлдэл. Зөвшөөрөлгүй хүмүүс, Бурхантай ямар ч холбоогүй байж Бурхантай ямар нэгэн холбоотой (оршихуйд байдаг) гэж өөрсдийгөө хэлэх нь худлаа юм. Тиймээс, тэд энэ хуруун дээрээ сэвтдэг. Тэд юу хийдэг вэ? Тэд эдгээр бүх аргуудыг ашигладаг. Энэ аргыг Санскрит хэлээр "Авидья" гэдэг. "Авидья" гэж мэдлэг бус. Үүнийг мэдлэг биш гэж хэлж болно. Оюун мэдлэгийн эсрэг. Бурхны эсрэг. Энэ бол Бурхны эсрэг юм. Үүнийг засах тарни бол "Шуддха Видья". Цэвэр (оюуны/Бурхны) арга барил гэсэн утгатай тарни юм. Цэвэр арга барил гэдэг тарни. "Цэвэр" гэдэг нь Амин Сүнснээс гаралтай гэсэн утгатай. С.йогчидын хийж байгаа зүйл бол цэвэр оюуны арга юм. Хүч нь сэргэцэн учир, урсан ундарч байна. Тэд гараа хөдөлгөхөөр, гараар нь хүч урсч, зүйлсийг засаж байна. Зүгээр нэг уран нугаралтын зүйл биш. Тиймээс, цэвэр мэдлэг бол, Жишээ нь, тэдний асаасан лаа нь, миний дэргэд, мөн (йогчид) өөрсдөө гэгээрсэн учир, зүйлсийг засаж байна. Энэ бол бүхэлдээ цэвэр "видья", цэвэр мэдлэг, цэвэр арга барил юм. Үүнийг хийгээгүй зарим нэг хүмүүс нь үзмэрч хүмүүс дэр очиж, тэдэнд толгой тонгойж, өвдөглөн мэхийж хийх ёсгүй буруу зүйлийг хийсэн байгаа юм. Тиймээс, ийм болдог. Ийм учир, энэ зүүн эрхий хуруу нь сэвтэж мэдрэгдэж байвал, тийм (муу) хүн дээр очисоны тэмдэг. Хэрвээ та гэдэсний орон зайнд ямар нэг халдвар авсан бол Энэ бол зүүн Свадистана. Энэ нь (гэдэсний) доор хэсэгт байдаг. Энэ нь бүхэлдээ тойроод баруун Свадистана-д, энэ талд ирдэг. Жишээлбэл, хүн алганы хонхорхойг тойроод гэмтэлтэй байвал. Зүүн, баруун алганд Хоосон орон зай гэдэг Бид үүнийг "войд" гэдэг. Зен-ий хоосон чанар биш, "Войд" нь гэдэсний хоосон орон зайг даван гарах хэсэг. Ходоод, гэдсэнд байдаг. Хэвлийн хөндийд байдаг. Энэ хэсэгт нь хэрвээ сэвтэлтэй байвал Гуру багш байх оюуны 10 зарчим сэвтсэний тэмдэг. Энэ нь гэмтэхээр, Гуру багшийн зарчмыг зөрчсөний тэмдэг юм. Мастер багшийн чанараас алдсан гэсэн үг. Ямар нэг буруу багш дээр очсон гэсэн үг. Энэ сэвтэхээр тийм утгатай. Саяхан, тэр хүн "войд" нь сэвтэй байна гэсэн. Кундалини нь тэнд нь эргэлдээд (дээш гардаггүй). Үүнийг өөрөө харж болно. Кундалини нь зайлуул тэнд бүхэлдээ булиглан цохилж. Бүх гэдэс нь хөөрөлд ордог. Тэгсэн тохиолдолд та Анхдагч Багшийн тарнийг хэлэх ёстой. Хэнийг нь ч дуудаж болно. Гуру Нанак, Мохамед-н нэрийг дуудаж болно. Бүгд мэргэд багш нарын оюун. Мозесийн нэр, Абрахам... бүгд тэнд байдаг. Тэдний нэрсийг дуудвал Кундалини нь дээш өгсдөг. Энэ хэсгээ сайжруулна, тэгвэл Кундалини нь дээш өргөгдөн гардаг. Эдгээр бүх йога-нууд, мөн бие махбодийн дасгалтай йоганууд... Бие махбодийн йога хийхэд хүн энэ хуруу мөн энэ хуруу нь сэвтэж мэдрэгддэг. Энэ баруун ядам хуруу мөн энэ зүүн чигчий. Энэ бол зүрх бие махбодио хэт их чухавчилсаны шинж. Мөн бие махбодио хэт их ачааллаж ажилладаг хүмүүс ингэж гэмтдэг. Мөн энд сэвтдэг. Учир нь та хэт их идэвхтэй бол үүний үр дүнд үйлдэл бүрийн хий чинь таны ЭГО-руу ордог Энэ бол барууны орны хамгийн том асуудал. Тэд том ЭГО-той гэдгээ ч мэддэггүй. Харин Оюун нь нээгдсэний дараа тэд өөрсдийн ЭГО-ны хий нь маш том болсоныг нь мэддэг. Тэгээд тэд "Эх минь, би баруун Агья-д сэвтээд байна" гээд ирдэг Энэ нь маш нарийн. Тэдэнд өөрт нь, та ЭГО-той бна гэж огт хэлж болохгүй. Тэгвэл хариуг нь хүртэнэ. Тэдэнтэй маш болгоомжтой ярихгүй бол болохгүй. Үнэндээ, маш олон хүмүүс өөрсдөө ЭГО-той гэдгээ мэддэгдэг Тэгээд хэт их ЭГО-гоо мэдэрэхээр архи уудаг, учир нь тэд өөрсдөө айгаад, үүнээс зугтахыг хүсдэг. Хүмүүс үүнийг ухамсарладаг. Харин Оюунаа сэргээсний дараа үүнийг бүхэлд нь ойлгодог болдог. Яагаад гэвэл хүн энэ хуруунд нь өвдөөд, энд нь өвдөөд, өөрт чинь энэ ноён ЭГО нь хийлэгдсэн нь мэдрэгддэг учир. Тэгээд та үүнийг яаж эргүүлж, яаж гаргахаа мэддэг болно. Та өөрийгөө мэддэг болно мөн бусдыг ойлгодог болно. Би хэлэх хэрэггүй. Та өөрөө мэддэг болно. Бид "долгион"-жуулсан ус уух зэргийг хэрэгжүүлж өөрсдийн "войд" гэдсээ цэвэрлэдэг "Долгион"-жуулсан ус гэж юу вэ? гэвэл Бурхны энергитэй болгосон ус байгаа юм. Тэр "долгион" нь тэр гэдэсний хэсэгт ирэн цэвэрлэн засаж эхэлдэг. Үүгээр бид маш олон гэдэс ходоодны хавдартай маш олон хүнийг эмчилсэн. Цусны өвчнийг хүртэл Сахажа йога-нд бид эмчилдэг. Маш олон хүмүүс эдгээрсэн. Та өөрөө эмчилж чадна. Та өөрөө чадна. Ямар ч асуудалгүй, та чадна. Харин хүн юу хийх ёстой вэ гэвэл, Сахажа йогоор тогтвортой хичээллэх. Жишээ нь, та Христийн талаар нэг төсөөлөл ойлголттой гэж бодье. Тэр ойлголт чинь үнэн биш ч байж болно. Үнэн ч байж болно. Тиймээс нүдээ нээлттэй байлга. Миний хэлсэн зүйл бүрийн Сахажа йогт та шалгах боломжтой. Гэхдээ үгүйсгээд хэрэггүй. Эхлээд шалгаад үз. Жишээ нь эрдэмтэн хүн, зүйлсийг эхлээд өөрөө очоод үзээд, шалгадаг. Тийм биздээ? Та зүгээр шууд үгүйсгэн энэ худлаа гэдэггүй биздээ? Учир нь таны мэдсэн зүйл болгон таны өөрийн ойлголт юм. Тиймээс, дотогшоо ор. Тэгээд дотогшоогоо орвол, нүдээ нээлттэй байлган зүйлсийг өөрөө хар. Тэгээд хүн өрөө хараад эхлэхээр энэ нь юмсыг мэдэх хамгийн сайн арга болдог Учир нь та бүхний

харж буй зүйл чинь энэ "долгион"-ы ухамсраар олддог. Жишээлбэл, та юм асуумаар байвал. "Эх минь, Бурхан байдаг юм уу?" гэвэл 3 удаа асуугаад л та хариуд нь "долгион" чинь нэмэгдэхийг мэдрэнэ. Энэ бол үнэн. Харин хэрвээ та ТМ (Чандаас халих) урсгалын талаар асуувал, гар чинь шатна. "Долгион" нь урсахаа байна. Тиймээс Бурхны талаар асуугаад энергийн "долгионоо" алдахгүй байсан нь дээр...

1983-0129, Public Program, False Gurus and Conditionings (part)

View [online](#).

Public Program, Delhi (India), 29 January 1983.

Үнэндээ, аливаа туйлшрал бол Бурхны эсрэг юм. Жишээ нь, хүний зулай нээгдэхээс өмнө ямар ч өсөлт байдаггүй, хөгжил, хувьсал байдаггүй, хүний оюун ухамсрын хувьд. Хүний оюун ухамсрын хувьд хүн юунд хүрсэн байна, тэр бүхэн нь төв мэдрэлийн системнд нь илэрдэг. Та бүхэн мэднэ, амьтад бол бохир, муухай, гоё гэх зүйлсийг мэддэггүй. Харин хүмүүс үүнийг мэддэг. Гэхдээ хүн, шинэ ухамсар оюун руу шилжих хэрэгтэй байгаа юм. Тиймээс болох ёстой бүх зүйлс нь бидний ухамсар оюунд л болох ёстой юм. Энэ хялбар зүйлийг хүмүүс ойлгодоггүй/мэддэггүй. Ийм учир, хүмүүс бүх зүйлд хэт туйлширдаг шалтгаан нь энд байгаа юм. Жишээлбэл, манай Энэтхэгийн уламжлалд зарим нэг хүн Рама бурхны нэрийг дууддаг... Энэ нь муу зүйл биш, Рама гэх сайн үг хэлж, сайныг дуудах зорилготой. Гэхдээ үүнд нэг зүйлийг мэдэх хэрэгтэй. Энэ нь гэгээнээс гэгээн нэр. Энэ нэрийг дуртай үедээ, зоргоороо олон удаа хэлээд байх зүйл биш, ганцхан л удаа чин сэтгэлээсээ "Шри Рам" гээд хэлэхэд л хангалттай. Гэтэл ямагт, үргэлжлээд давтаад байвал, энэ чинь ямар ч утгагүй болно, Тэр нэрийг огт хүндлэхгүй, үүнийг огт үнэлэхгүй байгаа чинь л харагдана. Ийм маягаар, та зүүн суваг руугаа ороод: "Өө, Рама, өө, Рамаа, хэзээ бид уулзах юм бэ?" гэж байдаг. Би нэг Муслим хүнтэй Махараштра (мужид) тааралдсан. Тэр хүн: "Би 'Намаз' залбирлаа хийхдээ 5 биш илүү их, 10 удаа хийдэг" гэв. "Бурханд хүрэх л гэвэл, би илүү хичээх хэрэгтэй", гэсэн. Тэр хүн тэгээд өдөр бүр 10 удаа мөргөл үйлдэн өвдөг нь бүхэлдээ гэмтсэн байв. Тэгээд тэр "Энэ арай Бурханд хүрэх арга биш байна", гэж бодож. Тэгээд тэр Кораны оронд Энэтхэгийн Гита зэрэг судруудыг судалж Санскрит хэл сурч Гита судрын талаар маш том лекц явуулдаг болж. Тэгээд түүнд өөрт нь, өөрөө жинхэнэ "ВИАСА" болсон мэт мэдрэмж төрж. Тэгээд тэр, "энэ арай биш ээ, бүгд хуурамч юм, үүнийг орхиё" гэж. Тэр шудрага... Тэгээд "бхакти" сүсэг рүү хандсан нь дээр гээд мансуурах тамхи татдаг урсгал руу очиж... Махараштрын Пандарпур хотод "Витхала мандхир" хийд байдаг, тэнд хүмүүс гудамжаар "Витхала, Витхала" гээд бурхны нэрийг эцэс төгсгөлгүй давтан алхдаг. Тэр хүн тэд нар дээр очиж. Тэгээд тэр урсгалын хүмүүс бүгд маш их тамхи хэргэлдэгийг харж. Тэгээд тамхиндаа мансууран трансанд орчихсон, "витхала, витхала, витхала.." гээд байхыг харж Тэр надаа хумсаа үзүүлсэн, бүх хумс нь хугараад гэмтчихсэн. "Би тэндээс Бурханг олоогүй, эндээс Пандарпураас ч мөн адил олсонгүй" гэсэн Тэр маш гонсойсон байсан. Би түүнд: "Энэ чинь юу вэ? Эдгээр бүх зүйл таныг юунд ч хүргэсэнгүй." Тэр хүн: "би бүүр өвчинд нэрвэгдсэн", "би тийш маш их очсон, очих бүрт өвддөг" "тэндхийн хүмүүс бүгд солиотой хүмүүс байсан" "би тэдэнтэй ярихад, тэд огт авцалдаагүй ярьдаг, эрүүл бус байсан" ямар утаггүй, юу болоод байгааг би ойлгодоггүй байсан. Тэгээд тэр: "Эх минь, би ямар алдаа хийв ээ?" гэв. Би: "Хэн чамайг Витхала гээд хэлээд бай гэсэн юм?" гэж асуув. Тэр: "Гнянешвара" гэсэн. Гэхдээ тэр (ХIII-р зууны гэгээнтэн) хэзээ ч тэгж хэлээгүй. Миний мэдэхээр Тэр хэзээ ч тамхи хэрэглээд, Пандарпур яв гэж хэлээгүй. Ийм зүйл хий, гэж хэлсэн гэж яагаад бодов? Гэхдээ тэр, "би Гнянешвара-г тэгж сайн мэддэггүй байсан, хүмүүс надаа унших юм өгөөд энэ Гнянешвара судраас гэсэн". Би: "Та маш их юм уншсан,мэдлэгтэй хүн." Тийм утгагүй зүйл ярьж буйг мэдмээр юм. Ямар ч эрүүл хүн тийм зүйл хэлээд явахгүй." Тэгээд, бид өөрсдийн бясалгалаа Бомбей-д байдаг Гнянешварын сүмд явуулах гэтэл Тэд: "Бясалгаж болохгүй" гэв. Марати хэлээр ... - "витала, витала" - хийх ёстой гэв. Би: "Яагаад?" гэв Гнянешвара тэгдэг байсан уу? Үгүй. Түүн шиг болохын тулд бид тэгдэг гэв. Ямар хачин тайлбар вэ? Гэхдээ тэр өөрөө тэгдэг байсан юм уу? Үгүй. Тэр төрөлхийн тийм байсан. Түүнд хүрэхийн тулд бид ингэх ёстой Би: "тийм зүйл хийснээр ямар нэгэн зүйлд хүрсэн хүн байна уу?" "Витхала, Витхала, Витхала.." гэж давтах ухаангүй зүйлийг хийснээр гэгээрсэн хүн байна уу? Тэд: "Үгүй". "Тийм хүн байвал аваад ир, би үзье" гэсэн. Хэрвээ хэн ч ингэж гэгээрээгүй, Гнянешвара өөрөө ч ингэдэггүй байсан юм бол, та нар яагаад хийгээд байгаа юм? Энэ бол нэг байдлын үзүүлэн show. Эсвэл юмнаас зугтах арга. Вино дарсны оронд хар тамхи хэрэглэж, мансууралд орон, амьдарлаас зугтаж байна. Нэг талаар үүнийгээ амьдарлаас ангид гэдэг. Бхакти сүсгийн нэг тал гэдэг... Нөгөөтэйгүүр, хүн нэг юм уншаад, гэнэт "оюунлаг, гэгээнтэн" болчихдог гэж үздэг. Хэн ч юу ч уншиж болно... Хүн нэг юм уншаад "оюунлаг, гэгээнтэн" болчихдог юм бол бүх зүйл амар... Тэгвэл хэн ч бясалгал зэрэг юу ч хийх шаардлагагүй, зүгээр л шууд нэг ном уншаад л бүхнээс мундаг ертөнцийн оргилд гарчихна. Энэ бүхэн зөвхөн бодол санааных. Хэн ч үүнийг хийнэ. Юу нь мундаг байгаа юм? Энэ бүхэн, бүгд бодол санааных. Тэгээд хүн эдгээр бодолдоо хэт туйлшраад, хүн хийж, сэтгэж, ойлгож байгаа юм болгоноо - бодол санааных болгодог. Улс төрөө хараач - бүгд бодол санааны төсөөлөл. Та бүхний капитализм, хөрөнгө ч үгүй байж, юу юм? Ямар нэг хүчтэй болов уу? Үгүй. Ямар хүчтэй болсон юм? Зөвхөн сүйтгэх, устгах л зэмсэгтэй л болсон. Ямар хүчтэй болов? Нэг цэцгийг ч гэсэн жимс

болгов уу? Үгүй. Ямар ч бодит хүчгүй байна. Үүнийг баялаг гэх уу? Мөн өгөх, түгээх зүйлгүй байж ямар коммунизм бүтээх билээ? Хэрвээ намайг хүчээр баян гэвэл, би хамгийн том хөрөнгөтөн. Гэхдээ үүнийг би ганцаараа эдлэхийг хүсдэггүй учир, би хамгийн том коммунист. Харин миний хөрөнгөтөн, коммунизмын илрэл бол бодол санааных биш. Бодитоор байдаг мөн бодитоор илэрдэг баялаг. Санскрит хэлээр "Кальяан" гэдэг. Ийм байх ёстой. Өөрөөр бол зүгээр төсөөлөл санааных... Нэг нь ЭГО, нөгөө нь СУПЕР-ЭГО үүсгэдэг. Эдгээр заншил нь хүнд хэтрэн туйлширч асуудал үүсгэж байна. Учир нь таны ухамсарын хөдөлгөөн нэг бол зүүн талд, эсвэл баруун талд Зүүн тал руу туйлширвал, эхлээд доод ухамсрын орон руу ордог. Энэ амьдралын өнгөрсөн/доод ухамсар луу орно. Тэгээд өнгөрсөн амьдралуудынхаа доод ухамсар. Дараа нь бүх ертөнцийн доод ухамсар луу ордог. Баруун суваг руугаа хэтэрвэл, ирээдүй рүү гээ - "дэд" ухамсар луу орон, тэгээд бүх ертөнцийн (дээд биш) "дэд" ухамсар луу ордог. Үнэндээ бол өнгөрсөн үе дууссан, ирээдүй гэх зүйл байхгүй. Төв голд харин бодит оршихуй бна. Гэхдээ хичнээн, "Өө, Эх минь, би одоо бодит оршихуйд" гэвэл энэ чинь үнэндээ тийм биш. Ойлго. Энэ үнэн биш. Энэ бол зүгээр бодол санааных. Би тийм, ийм гэх бодол. Зүгээр өөрийгөө би ийм, би тийм, гээд хүлээх нь таны тийм гэдгийг нотлохгүй. Энэ маш чухал, зүгээр ЭГО/СУПЕРЭГО бодлууд руугаа зугтахын оронд, өөрийгөө ямар буйгаа хүлээж ойлго. Энэ маш чухал. Хэрвээ өсөхийг хүсч байвал, хэр хол буйгаа мэд... Жишээ нь, онгоц нисэхэд хэр их түлштэй байна, тоног төхөөрөмж нь сайн эсэхийг мэдэх шаардлагатай. Үүнтэй адил, та өөрийн хаана байгааг олж мэд. Би өмнө хэлж байсан, Бурхан бол, хүн итгэнэ үү, үгүй юу, байдгаараа л байдаг. Та бүхэн Бурхныг өөрсдийн төсөөлөл, бодлоор, ЭГО-гоороо ойлгох боломжгүй. Ойлгож чадахгүй. Тиймээс, бодол санаагаа нээлттэй, "тэр" хэн юм бэ гэдгийг харсан нь дээр. Энэ бол тогтсон үзэл бодлыг сөрөх анхны, жижигхэн л алхам юм. Үүнийг ойлгоод ирвэл, хичнээн ч их лекц, ном унших, аливаа бодол санааны, ном сонсох гм. зүйлс хүний хөгжүүлэхгүй, зөвхөн ЭГО-г чинь хийлж хөөргөнө, юм хардаггүй болгоно. Үүгээр барахгүй, Кундалини-г чинь өгсөх боломжгүй болгодог нь харамсалтай. Бурхан бидэнд юуг зохицуулж бэлдсэнийг харъя... Миний хэлсэнд итгэх хэрэггүй, гэхдээ бодол санаагаа нээлттэй хар. Бурхан бидэн доторхыг гайхалтай сайхан зохицуулсан. Кундалини нь өгсөхөд тэр Кундалини нь энэ улаан цэгтэй хүрдээр нэвтрэн гардаг. Энэ нь энэ хүрдний цонх нь юм. Нүдний мэдрэлийн зөрлөг дээр байрладаг. Энэ маш нарийн хүрд. Энэ хүрд нь парасимпатик мэдрэлийн хувьд Өнчин тархи болон Булцуут булчирхайг удирдаж бдаг. Мөн дараагаар ЭГО, СУПЕРЭГО-г хариуцдаг. Өнчин тархи нь ЭГО-г хянадаг. Булцуут булчирхай нь СУПЕРЭГО-г. СУПЕРЭГО нь нэг талаас бидний карма гэж нэрлэх үйлийн үр байгаа юм. "Өө, Бурхан минь, би нүгэл хийчихлээ, буян хийчихлээ" гэж хүний боддог эдгээр бодлууд. Нөгөө талд, ЭГО-ны хэсэгт, хүмүүс толгойндоо, "Би ийм/тийм/ мундаг", "Би ийм агуу юм хийсэн", "Би бүх ертөнцийн эзэн" гэсэн бодлууд цуглуулсан байдаг. Энэ бүх хэтэрчихсэн тархины хий нь, ЭГО, СУПЕРЭГО-г үүсгэж энэ толгойн хэсгийг бүрхэн хааж, энэ нь ясжин хатуужиж хүн (өөрөөс/бусдаас) салангад, тусгаарлагдмал болж -НОЁН 'X,Y,Z' болдог За, Кундалини нь юу хийдэг билээ? Кундалини нь энэ хүрдийг нэвтрэн гарч ирэнгүүтээ, тэнд байдаг Бурхныг нь амилуулдаг. Хүмүүс үүн дээр бүдэрдэг. Учир нь хүний ухаанаар Бурхан гэж ойлголт байдаггүй. Өөрөө Бурхдын Бурхан учир. Өөрт нь Бурхан байдаг гэдгийг яаж мэдэх билээ? Хэрээс нь хэтэрсэн зүйл... Яагаад гэвэл тэр нь бүх зүйлийг хийдэг, бүхнийг чаддаг. Тэгэхлээр, Бурхан нь байдаг. Тэнд нь тухлан залран, сэргэдэг. Энэ Бурхан нь маш онцгой. Энэ хоёр ЭГО, СУПЕРЭГО гэх тархины 2 хийг сорж арилгадаг онцгой Бурхан. Ингэж сорсноор энэ зулайн хэсэгт хонхор цоорхой, "Брахмарандра" үүсдэг. Тэгсэн тохиолдолд Кундалини нь дээш харвасан сум шиг хөөрдөг. Эхлээд мэдээж хүний тархи руу нэвтрэдэг. Тэгээд (мууг нь) сороод, нээгдүүлдэг. Тэгээд Кундалини нь харван өгсөж, хүн Ариун Сүнсний сэрүүн салхийг зулайнаас нь ялгарч буйг мэдэрнэ. Энэ бол хүн өөрөө харах боломжтой, бодит идэвхжилт байгаа юм. Гэхдээ өөрийн чинь -ухамсар оюунд- юу болох нь чухал юм. Би өмнө хэлж байсан. Энэ бол таны өөрийн, хүний түвшний оюун ухамсар шинэ ухамсар, оюуны түвшинд шилжих үйл явц юм. (Нааш ирээд суу, зүгээр зүгээр). Шинэ ухамсар оюун руу. Тэгэхлээр, тэр шинэ оюун ухамсар гэж юу юм? Бид юуг хүлээх ёстой юм? Та бүхний нэвтрэх тэрхүү шинэ ухамсрын оюун бол даяар нийт гэгээрлийн оюун юм. Даяр нийтийн ухамсарлах оюун. Энэ ухамсар оюун бол лекц юм уу ямар нэг гайхуулах шошго, тэмдэгтэй зүйл биш, ямар нэг хуурамч үзэл бодол биш, харин бодитоор таны ухамсарт болж буй оюуны өөрчлөлт юм. Та энэ гэрэл, эдгээр цэцгийг харж байгаатай адил үүн шиг, тодорхой, бодит зүйл. Бусдыг өөр дотроо мэдэрч эхлэнэ. Бусдыг мэддэг болно гэсэн үг юм. Тэдний хүрднүүд, төвүүд мөн өөрийн хүрднүүдийн байдлыг мэддэг болно. Мохамед Сахиб үүнийг хэлж байсан, "Дахин төрж, гэгээрэх үед гар чинь ярих болно", гэж. Эдгээр гар чинь ярьж эхлэнэ. Энэ нь яриад эхэлвэл, танд зөвхөн кодыг нь тайлж өгөх хүн хэрэгтэй. Иймээс би энд ирсэн юм. Олон хүмүүс намайг эсэргүүцдэг. "Та юу?" гэдэг Тэгвэл өөрсдөө хий л дээ. Би тэтгэвэртээ гарч амарвал баярлана. Хэрвээ та бүхэн хийж чадвал, би маш талархана. Энэ бол инээд хүрмээр зүйл. Би зөвхөн ганц зүйлийг л мэддэг. Кундалини-г сэргээж чаддаг. Мөн утга учир, кодыг нь тайлахыг мэддэг. Та бүхэн маш олон, өөр зүйл мэднэ. Тиймээс, надаа дургүйцээд байх ямар хэрэг байна?. Энэ маш төвөгтэй, хэцүү ажил, үүнийг би энд дурдах хэрэгтэй. Заримдаа надаа, маш их хад чулуу

өргөж байгаа л юм шиг санагддаг. Гэлээ ч, би үүнийг яаж хийхийг нь мэддэг. Тийм учир би энд та бүхэнд, гартаа мэдрэгдэж буй зүйлийг хэрхэн тайлах талаар заахар энд байгаа юм. Юун түрүүнд юу болох вэ гэвэл, та бүхэн гартаа сэрүүн салхийг мэдэрч эхлэнэ. Кундалини нь сэргэхээр. Үүнийг (Кундалини-г сэргээх) та бүхэн, ямар ч тохиолдлоогр, хийж чадахгүй. Жишээ нь зари нэг хүн, өөрийн хувцсаа онцгой өнгөтэй болговол, тухайн өнгөтэй болговол Бурхантай болно, гэдэг. Тийм амархан. Ялангуяа Энэтхэгт жаахан мөнгө төлөөд л хувцсаа будуулж болно. Яагаад? Яагаад тэгдэг байна? Зарим хүмүүс, маш хурдан, хурдан үсэрвэл Бурхантай болно гэдэг. Үүнийг хэн ч, хэзээ ч хийх зүйл. Юу нь агуа байна? Нэг удаа, нэг хүн над руу хөлөө жийгээд сууж байв (газар). Хүмүүс, чи ингэж сууж болохгүй, Эхийг хүндлэх хэрэгтэй, гэв. Үгүй ээ, би хүндлэмээр байдаг, гэхдээ хөлөө зөрүүлж суухаар мэлхий шиг үсрээд эхэлдэг, гэв. Тэгээд би түүнийг дуудаад, яасан юм гэж асуув. "Эх минь, би мэлхий шиг үсрээд эхэлдэг юм" гэв. Би: "Яагаад" гэв Тэр: "Миний Кундалини сэргээчихсэн учир, мөн манай багш надаа, Кундалини чинь сэргэхээр, мэлхий шиг үсэрч эхэлдэг гэсэн." Тэгээд надаа бүүр энэ талаар бичсэн ном үзүүлсэн. Тэгээд тэр багш нь олны мэдэх хүн. Тэр одоо, гэхдээ амьд биш, гэж бодно. Тэр маш их мөнгө хийсэн багш, хүмүүс түүний цуглуулсан очир эрдэнэсийг яахаа мэдэхгүй бсан. Мөн хүмүүс бид зүйлсийг ойлгохгүй байна. Хүн яагаад мэлхий шиг болох ёстой юм. эсвэл газрын өт шиг Та бүхэн агуа сэтгэл болох ёстой. ямар ч хүн өөрөөс чинь салангад, тусдаа биш гэдгийг мэдрэх ёстой түвшин. Бусдыг өөр дотроо мэдрэх түвшин. Тэгээд хүнийг тийм болгохгүй байтал, яаж тийм хуурамч зүйлд хялбар автаж байна? Хүний хувьсал хөгжилд хүртэл юу ч нэмэртэй юм өгөхгүй байхад. Жишээлбэл, загсыг аваад үзвэл, энэ нь сэлдэг. Яст мэлхий бол мөлхдөг. Хоорондоо ялгаатай байдаг. Мөн оюун ухамсраараа ялгаатай. Нэг нь усыг мэдэрдэг, нөгөө нь газрыг мэдэрдэг. Энэ (Сахажа йога) нь юу гэж хүнд хоосон итгүүлсэн зүйл байхав дээ. Хэрвээ энэ нь тийм ховсдол байсан бол юу гэж оюун ухаанаа алдсан хүнийг эмчилж чадах билээ? Хавдар болон тийм бүх өвчнүүдийг эмчилж хүнийг эрүүл болгодог байхад юу гэж хүнд итгүүлэх зүйл байх билээ? Ворен үүнийг та бүхэнд нотлоно, Австралид нэг эмэгтэй ухаангүй, хэвтэрт байсан, намайг очихоос өмнө. Тэгээд нэг сахажа йогчин байгалийн ухаанаар эмчилдэг эмэгтэй байсан Тэд өвчтөнг тэр эмэгтэйд үзүүлсэн байсан. Тэгээд тэр, надаа эмчилэх ганц л арга байна, би Эхийн зургийг орон дээр нь тавья, гэж. Тэд (гэр бүлийнх нь) өвчтөнг үхнэ л гэдэгт итгэсэн байж. Босгох ямар ч арга байхгүй гэж бодож. Гэтэл маргааш нь ухаан орж. Тэгээд ухаан ороод, бага зэрэг юм бувтнаж эхэлэхэд, эмч нар түүний тархийг гэмтсэн, согогтой болно, гэмтэл согогтой хүн болно, хэдийнээ найдваргүй гэмтсэн тархитай гэж эмч нар оношилсон байсан. Гэтэл тийм биш. Тэр зүгээр болоод, өнөөдөр сахажа йогт ажиллаж байна.

Миний хувьд энэ ид шид биш. Харин та бүхэнд энэ нь ид шид, үүнийг үзээгүй, мэдээгүй учир. Маш олон гайхмаар зүйлсийг өдөр бүр харж байгаа. Гэхдээ гайхдаггүй. Та бүхэн нэг эд эснээс өнөө хүртэл хөгжин хувьссаар ирсэн. Харин яаж? Бурхан биднийг ямар сайхан зөөлнөөр хөгжүүлж үүсгэсэн байна. Бидэнд хатгах зүйл ч мэдрэгдээгүй. Яаж яваад бид хүн болсон юм, үүний талаар огтхон ч боддоггүй. Байдаг л зүйл гэж авдаг Харин та бүхнийг хүн болгосон, ямар их агуа хүч байгаа бол... Ийм маягаар ойлгох хэрэгтэй, хүн хөгжлийн хувьслийн явцаар дэвшиж, оюун ухаанаар хөгжин, шинэ ухамсартай болох ёстой. Энэ нь, энэ "Брахмарандра" нь нээгдэх үед, Сахасрара нь зулайн хэсэгт бүрэн нээгдэж, Кундалини-г нэвтрэн гарах боломж бүрэлдэхээр болдог. Сая, нэг хүн надаас нэмж асуусан "Яагаад ингэх хэрэгтэй юм? Яагаад Бурхан биднийг зүгээр анхнаас нь тийм (оюунлаг) болгоогүй юм?" "Кундалини-г нь сэргээх ямар хэрэгтэй юм?" Шалтгаан нь бол хүний оюун ухаан нь юун түрүүнд хөгжих хэрэгтэй юм. Бага, багаар. Аажмаар Та бүхэн нэг эснээс өнөөгийн түвшин хүртэл хөгжихдөө. Нүүрс төрөгчөөс 1 эст үүсч, 1 эснээс өнөө хүртэл бүрэлдэн хөгжих явцад, бидэн дотор (тэд схем-нд байхгүй байна, гэхдээ номонд чинь байгаа) төрөл бүрийн хүрднүүд бүрэлдэж, бидний хөгжил дэвшлийг тодорхойлсон. Хамгийн сүүлийн хүрд нь Сахасрара юм. Энэхүү түвшинд хүмүүсийн бүх хүрднүүд сайтар боловсорч гүйцсэн. Сахасрара чинь хүртэл боловсорсон. Тэгээд та бүхэн юу хийх ёстой вэ гэвэл, зүгээр л Бурхантай холбогдох үлдсэн. Холбодог холбоос мөн байдаг, энэ нь бол Кундалини, 3 бүхэл ½ хуулиастай, нугасны доорх гурвалжин ясанд нойрсож байдаг Энэ холбодог хүчийг нь сэргээж, толгойн хэсгээр нэвтрэн гарвал хүн даяар бүх нийт оюуныг мэдэрч эхэлдэг. Ийм үйл явц болдог. Энэ нь үр соёлуулахтай адил маш энгийн үйл явц юм. Гэхдээ, та үр соёолжийг зүгээр бүжилгээд, дуулаад, эсвэл үүний талаар ном уншаад соёлуулахгүй. Газар Эх-т суулгах хэрэгтэй байдаг. Үүнтэй адил үрийг соёлуулах чадвартай хэн нэгэн, тэр хайрыг агуулсан, Кундалини-г ойлгох чадвартай хүн үүнийг хийх ёстой байдаг. Энэ нь тэгээд болсон тохиолдолд, нэг лаа нь нөгөө лааг асаахтай адил болдог... Шинэ гэрэл нь эхлээд өөрийгөө бататгах хэрэгтэй, мөн бусад гэрлийг асаахыг сураад, хийж эхлэх хэрэгтэй. Ийм маягаар, шинэ ухамсрын хэжигдэхүүн рүү хөдлөх ажил явагдана. Үүнийг бид "Чайтанья", Гэгээрсэн оюун, ухамсар, Оюуны мэдлэг гэдэг Тэгээд энэ оюун танаар дамжин урсаж эхлэнэ. Энэ нь юу билээ? Та үүнийг толгой дээрээ, эргэн тойрондоо мэдрэнэ. Өмнө огт мэдэрч байгаагүй зүйл байгаа. Энэ бол таны нэвтэрсэн, Даяар Оюун Ухамсрын оршихуй юм. Та

өөрөө, шинэ ухамсрын хэмжигдэхүүнд нэвтэрнэ. Ийм зүйл хүмүүсд тохиолдох ёстой. Загас нь яст мэлхий болж, яст мэлхий нь гахай болж (хөгжлөөр) боловронгуй болсонтой адил хүмүүс ийм болох ёстой. Гэхдээ хүмүүс хамгийн хэцүү адармаатай нь, Яагаад гэвэл хүнд байдаг 2 асуудлын улмаас, хүлцэлийн талаарх бодлын улмаас, хүн дээд хүчинд уусч чаддаггүй Хоёрдугаарт, хэрцгий чанар, эсвэл "ЭГО"-ны эсвэл "СУПЕРЭГО"-ны хандлагаас болдог. Хүн өөрийн "ЭГО"-гоо хянахыг хүсээд "СУПЕРЭГО" руугаа орчихдог. Жишээ нь, хүн маш их "ЭГО"-той бол, хүн өөрөөсөө маш их эвгүйцэж хар тамхи, архи дарсанд ордог. Яагаад гэвэл үнэн байдлыг дийлэхгүй, зугтахыг боддог. Унтаж ч чадахгүй болоод ирэхээр, эдгээр зүйл рүү хандаж эхэлдэг. Харин "СУПЕРЭГО"-той хүмүүс нь, орчин үеийн шаардлага, төсөөллийн дагуу хөгжиж чадаагүй, дутуу хүмүүс нь тэд "ЭГО"-ны хандлагатай болдог. Харин хөдөлгөөн нь, нэг бол баруун, нэг бол зүүн тийш, 2 тийшээ л саваад байна. Харин өсөлт дэвшил бол өөдөө явагддаг. Энэхүү өсөлт дэвшилд зөвхөн Кундалинийн амьд үйл явцаар л хүрэх боломжтой. Энэ Кундалини-н талаар та бүхэн их юм сонсож, их юм уншсан байх. Үнэндээ би маш гайхсан. Би бага байхдаа Кундалини талаар ном уншаад, "Өө, Бурхан минь, одоо хүмүүст яаж тайлбарлана даа", л гэв Нэг зүйл дээр: би хэзээ ч ном бичихгүй гэж шийдсэн юм. Зүйлсийг ойлгох түвшинд хүртэл нь... Тэгээд би, эдгээр Кундалини талаар маш том том номнууд бичсэн хүмүүсийг яаж илчлэх вэ, Кундалини нь хаана байдаг гэдгийн ч мэдэхгүй байж, энэ нь хамарт, гэдсэнд, зүрхэнд нь байна уу, бичиж байдаг Туйлын харанхуй хүмүүс бичсэн. Та бүхэн гайхна. Жишээ нь нэг хүн, ямар нэгэн салбарт, юуны ч талаар ингэж бичвэл, та тэр хүнийг шүүхэд дуудаж, зайлуулна, гэтэл Бурхантай холбоотой зүйлийг, Наполеон, Гитлерээс эхлүүлээд, бүгд дуртайгаа бичиж байдаг. Хэн ч Бурхны тухай дуртайгаа ярьж байдаг. Эдгээр хуурамч багш нарын ихэнх нь, Бурхны талаар, Дээд Оюун, Дээд ухамсрын талаар ярьдаг хүмүүс. Тэд бүгд гэмт хэрэгтнүүд юм. Бурхны эсрэг, Христын эсрэг хүмүүс юм. Харин тэднийг хэн илчлэх вэ? Мэдээж, тэд сүүлд нь өвчилдөг, шавь нар нь өвддөг, бүгд зовдог. Үүнийг өөр, хамаагүй зүйл гэдэг. Хэзээ ч холбож хүлээдэггүй. Хязгааргүй үнэнч, зовсон ч гэлээ. Би нэг эмэгтэй багшийг мэднэ. Бүх шавь нар нь зовлонд нэрвэгдсэн. Бөөрний асуудал, зүрхний өвчин, даралт нь өгсдөг болчихсон. Багш хүн чинь, хамгийн наад зах нь эрүүл байлгах ёстой биздээ? Тэгээд, энэ эмэгтэй хуурамч мэхтэй гэдгийг нь шавь нарт нь ч хэлж болохгүй. Үүгээр ч барахгүй, тэр нууцмагтаа маш шог эмэгтэй байсан. Үүнийг нь хэлчихвэл тэд үнэхээр таныг буудахаас ч буцахгүй. Тэр шавь нар нь бүгд, дотроо ямар нэг асуудалтай болчихсон. Гэр бүл нь бутарсан. Бүх зүйл болж байхад "Багш л бол Багш"- гэдэг. Юу ч хийлээ, тэр бидний багш, яаж ч байлаа, бид түүнийг орхихгүй Зүү, гээд өгсөн сахиус зүүлтнээс нь хэзээ ч салдаггүй, наалдсан пад болдог. Тэд юунд ч хүрээгүй. Өөрсдийн хүчийг ч нээлгээгүй. Хамгийн наад зах нь тийм багш дээр байсан хүмүүс, юунд хүрсэнийг хараач. Бид эдгээр зүйлд зүгээр шууд маш их, мунхран татагддаг. Тэдний тоглож буй цирк/жужиг, эсвэл тэр цуглуулсан мөнгөөрөө сонин,ТВ-р өөрсдийгөө суртачилахаар нь автаж байдаг Тэдний хүн мэхлэх хэр хэмжээ бидний ухаангүй байдлаас арай илүү байгаа учир тэд өдий хүртэл үргэлжилсээр байна. Тэд мөнгөний төлөө, юун түрүүнд зүтгэдэг. Бид тэдэнд мөнгө өгөөд Бурхныг худалдан авч бна гэж бодно. Маш олон хүн Бурхныг мөнгөөр олдог гэж бодно. Бурхан мөнгийг мэддэггүй. Тэр мөнгийг ойлгодоггүй. Мөнгийг огт үзээгүй. Хэрвээ надаас асуувал, би чек бичихээ ч мэддэггүй, бусдаас асууж болно. Би мэддэггүй. Манай нөхөр надаа зааж л байсан. Гэлээ ч би мэддэггүй. Миний тархи тийм юманд ажиллахаа байчихдаг. Сурах гэж үзээд, үзээд, чадаагүй. Миний өмнөөс хүн бичих хэрэгтэй болдог, тэгээд л би гарын үсгээ зурдаг. Сонирхол минь тэнд байдаггүй учир. Тийм багш хүн, таны түрүүвч, таны бүсгүй, эд хөрөнгөнд чинь сонирхон, дурлана гэж яаж болдог юм? Хүнд байдаг хамгийн муу заншил бол, мөнгө төлөөд Бурхныг олно гэж бодох явдал юм. Харанхуй хүмүүсийг ойлгож байна, тэд тэгдэг. Намайг тосгонд очиход хүмүүс мөнгө өгдөг, Нэг эмэгтэй надаа 5 Пи өгөв. Би мөнгө авдаггүй, гэв. Гэтэл, тэр, "За, би танд 10-г өгөх үү?" гэсэн. Яагаад гэвэл, тэд маш энгийн, маш их тогтсон заншилтай учир ойлгодоггүй. Гэхдээ, тэд энгийн зандаа, маш хурдан зулай нь нээгддэг. Гэхдээ хялбар биш, их юм мэддэг хүмүүс хүртэл эдгээр аймшигтай багш нарыг дагаж бдаг. Тэдэнд Бурхны эсрэг, Христийн эсрэг бүх зүйлийг зааж байдаг. Үнэхээр, Бурхны эсрэг гэдэг нь тодорхой. Тэгээд өвчинд нэрвэгдэж, асуудалд унахаар... Нэг маш баян байсан нэг эмэгтэй манайд ирсэн... Нөхөр нь дампуурсан. Хүүхдүүд нь солиорсон. Тэр эмэгтэй унадаг болсон. Нөхөр нь татдаг өвчтэй болсон. Тэгээд бүх зүйлээ алдан ядуурч бүр юу ч үгүй болсон хойноо Сахажа йоганд ирээд одоо зүгээр болсон. Гэхдээ нөхөр нь дампуураад, Лондноос явах шаардлагатай болсон. Гэтэл тэр ноён "Багш" нь одоо 6 мянган крор Рупитай болсон (1крор=10.000). 60 сая Рупи Гэхдээ хэн ч түүнийг хаанаас яаж мөнгө олдог гэдгийг тоодоггүй. Нэг зүйлийг хүн ойлгох хэрэгтэй. Юм хайгуулчилж байна гээд хүн тархиа зарах ёсгүй юм. Юм хайх нь зөв. Гэхдээ тархи чинь эрүүл байх ёстой. Тархиа орхих ёсгүй. Зүйлсийг эрүүл ухаанаар ойлгох хэрэгтэй. Энэ бол тэгээд тэр гэгээн, буянтай бүхний эсрэг байдаг зүйл юм. Гэтэл үүнийг хүмүүс хэд хэдэн мянган жилээр хийсээр ирсэн. Бага хэмжээгээр байсан бол одоо бүүр илүү их тархан, үнэхээр том ёс болчихсон. Хэн ч үүнийг эсэргүүцэдгүй, хэн ч тэдэнд юм хэлдэггүй, хэн ч үнэн байдлыг нь бичдэггүй. Яагаад гэвэл тэд мөнгөтэй учир. Харин хайгуулчид соргог байх хэрэгтэй! "Би юу хүсч бна?"- мэдэх хэрэгтэй. "Би өөрийн Амин сүнсээ хүсч байна уу? Эсвэл "мундаг багштан" хөлсөлсөн

хүн болж харагдмаар байна уу? Хоёрдугаарт, бид оюун ухаандаа маш чухал, хязгааргүй чухал өртөг, түвшинд хүрэх хэрэгтэй. Тэр бол, бидэнд (дотор) ямар нэгэн зүйл болох ёстой. Бидний өөрсдийн хүч илрэн нээгдэх ёстой. Гуру багшийн хүчнээс шалтгаалж, хамаарах ёсгүй. Жишээ нь, миний талаар хүмүүс их зүйл ярьж болно, юу ч дуртайгаа, гэхдээ, та өөрөө тэр агуа хүчийг өөрөө олохоос нааш, үүнд итгэх ямар хэрэгтэй юм? Ялангуяа, Энэтхэгчүүд бид хүн бүрийн хөлөнд мөргөх муу заншилтай Тэр хүн нь маш муу, маш сөрөг, хамгаас муу нүгэлтэй хүн байж болно. Зүгээр л гаднаа дүр исгэдэгт нь болж хөлөнд нь ёсолж байх ямар хэрэгтэй юм? Шулуухан хэлэхэд, миний хөлөнд хүн бүр гар хүрэхэд би дургүй. Учир нь, Энэтхэгт хүн бүр хөлөнд минь гар хүрээд, зарим нь маш муу байснаас, арьс минь цэврүүтдэг. Харин тосгоны хүмүүст, Эхийн хөлд бүү хүр, гэвэл, энэ нь хамгийн том гутаалт болдог. Хүн бүрийн хөлөнд хүндлэл үзүүлдэг. Юунд нь болж? Эдгээр аймар хүмүүст тонгойх ямар хэрэгтэй юм? Тэднийг муу гэдгийг мэдээгүй байлаа ч, мэдсэн байлаа ч үргэлжлүүлээд ёслоод байх юм... Гэхдээ, тэдний хэн гэдгийг мэдээгүй бол, шууд мөргөөд байх шалтгаангүй шүү дээ. Би нэг ламыг иш татан ярья. (Лам нар мөн бас толгой өвтгөсөн хүмүүс). Нэг лам Швед яваад захиа бичиж, Баруунд хүмүүс нь "амьдарлаас татгалзсан" хүнийг хараад сүйд болдог. Энэтхэгт хүртэл... "Амьдарлаас татгалзах мөрийг хөөсөн" хүн айл гэрт орж болохгүй гэж Ситажи, маш тодорхой бичсэн. Тийм хүн тосгоноос хол, уул хаданд, хот айлаас хол байх ёстой. Түүнд хоол өгч болно, тэгээд л болоо. Гэрийн ямар ч эмэгтэй хүнтэй ярилцаж болохгүй. Мөн ямар ч мөнгө өгөх ёсгүй гэж байдаг. Тэр Валмики-н судрыг өөрсдөө унш. Үүнээс болоод хамгийн их зовдог хүмүүс нь, дотроос нь гадна нь хүртэл, үнэхээр зовсон, тэр бүх тосгоны хүмүүст мэдүүлэх хэрэгтэй. энэ талаар хэдийнээ сударт бичсэн байдаг гэдгийг хэлэх хэрэгтэй. Амьдралыг огоорсон санваартан хүн хот суурингаас хол байх ёстой гэж заасан байдаг. Гэрийн аж ахуй хөөцөлдсөн хүмүүс амьдралыг огоорсон хүнээр яах билээ? Тэгээд хүн нэг зүйлийг олж мэдэх хэрэгтэй. Шашин ярьдаг, шашин боддог бүх хүмүүс мөн шашиныг нэвтрүүлдэг хүмүүс өөрсдөө яаж амьдарч байна харах хэрэгтэй. Тэд яаж амьдарч байна. Шимэгч хорхой шиг байна уу? Тэд хамгийн дорой сорон мөлжигчүүд юм. Нэг лам, намайг ирэхэд боржигон чулуун зам зас тэгэхгүй бол би ирэхгүй шүү гэж шавь нараасаа шаардаж байсан. Шведэд тэр боржигон чулуун шал бэлдүүлж байдаг. Тэгээд зайлуул шавь нар нь зовж байж шалыг нь чулуугаар засч, тэр лам багшаа ирүүлж. Тэд Төвддөө сорон мөлчигч нар байсан бол одоо тэд мөн тийшээ очиж. Тэгээд бид мөнгө төлж байдаг. Яалаа гэж? Ямар сайн юм бидэнд өгсөн юм? Тэргүүн шимэгчүүд. Шимэгч хорхой шиг хүн Гуру багш байж болно гэж үү? (Эх минь, уучлаарай, бид энд Кундалини-н талаар сонсох гэж ирлээ, "өөр" зүйл биш) Явмаар бол яваг Би маш зөв сэдэв хөндөж, явах ёстой хүмүүсийг нь явуулах. Би маш баяртай байна. Тэр Кундалини-н талаар мэдэхийг хүсч. Гэхдээ Кундалини-г мэдэхийн тулд өөрийгөө хэн гэдгийг мэдэх хэрэгтэй. Хэрвээ та эдгээр буруу багш нараас ирээд, тэднээсээ салаагүй байх юм бол би танд сайныг өгч чадахгүй, би шууд хэлэх хэрэгтэй. Би та бүхний Эх, та бүхэнд таалагдана уу, үгүй юу. Би худлаа юм ярьж чадахгүй. Тэдний үнэнг сонсохыг хүсэхгүй байвал явсан нь дээр. Хэлэх юм үгүй, надаа. Харин буруу хүмүүс бол буруу. Тийм хүмүүсийг орхих хэрэгтэй. Үүнд би та бүхнийг бэлтгэх хэрэгтэй. Учир нь маргааш... Өнөөдөр та бүхэн хүчээ сэргээнэ. Би мэднэ. Миний ажлын улмаас. Гэхдээ энэ чинь дахиад уначихна. Өөрийн бүх энергиэ, буруу багшийг дагсанаар бүр мөсөн алдана. Бусдыг маш их зовоож, маш их мөнгө олсон багш байтал хөлөнд нь очсоор байх уу? Тийм байж, өөрийн Эхийн ерөөлийн хүртэнэ гэж үү? Хуурамч бүхнийг та бүхэн хаях хэрэгтэй. Үүний талаар би ярьж байна. Нэг багштай байдаг. Яагаад түүндээ тийм их хорогдоно вэ? Танд юу өгсөн юм? Та түүнд л мөнгө өгсөн. Тэгээд би мөнгө өгч болохгүй гэхлээр, та өмнөөс нь гомдоод байдаг. Хамаагүй. Мөнгө өгсөн байлаа ч энэ хамаагүй. Энэ огт хамаагүй. Та ямар ч алдаа хийлээ, миний хувьд зүгээр Гэхдээ та өөрөө мэдэх хэрэгтэй, энэ алдаа бол, дахиж эдгээр ямар ч зүйлийг давтахгүй байх Үүнийг та бүхэн мэдэх хэрэгтэй чухал зүйл юм. Та, Бурхны эсрэг хүмүүстэй хамт байгаад Бурхантай хамт байх боломжгүй. Тийм биз дээ? Хоёр (эсрэг хүчний) багштай байх боломжгүй. Тийм биз дээ? Тиймээс, юм хайж буй хүн юун тэргүүнд эрүүл ухаанаар, "Би өөрөө өөртөө эзэн" гэдгийг мэдэх хэрэгтэй. Би өөрөө өөрийн багш Миний хүчийг сэргээдэггүй хэнд ч бай, би ёслохгүй Ийм маягаар сахажа йогийг ойлгох хэрэгтэй. Сахажа йога нь хүнд үнэнийг өгнө Хуурамч зүйлийг өгөхгүй. Хүний хийж чадахгүй, хүн үл ойлгох зүйл өгөхгүй. Бүх зүйлийг та бүхэн эрүүл ухаанаар ойлгоно. Үнэнийг хайдаггүй, оюуныг хайдаггүй, эсвэл("багш" гэх) хүмүүсийн боол болсон хүмүүст бодь болгох Оюунаас би өгж чадахгүй. Та бүхэн зөвхөн Бурханд л захирагдах ёстой. Өөр хэнд ч биш. Багш хэрэгтэйг би ойлгож байна. Гуру багш хэрэгтэй. Гэхдээ үнэн багш байх ёстой. Үнэн багш нар маш их бий. Маш олон үнэн багш нар Махараштра-д байдаг, би мэднэ. Тэд ирээд, надаа хэлдэг: "Эх минь, та үргэлжлүүл дээ. Гэхдээ тэд үнэнг нь хэлсэн хүнд хэзээ ч дургүй байдаг. "Тэд худлаа ярьдаг, хуурамч, өөрсдийг нь мунхруулдаг хүмүүст л дуртай байдаг." Тэд бүгд хүмүүсийг голдог. "Бид өдий хүртэл тэр хүмүүсээс бид барьдаг. Тань шиг биш." "Гэхдээ хэдэн жилээс бид уулнаас бууж очиж магадгүй." Би нэг (тийм жинхэн) багшийг Америк руу явуулсан. Чи наанаа боловсруулаадх гэсэн. Тэр маш эрч хүчтэй хүн байсан. Гэхдээ тэр 3 өдөр болоод буцаад ирсэн. 3 өдөр болоод Америкаас ирээд, тэр: " Тэнд хүмүүс нь Бурхныг хайдаг гэж бодож байна уу? Үгүй

ээ" "Тэд, мөнгөөр худалдаж авах Багш л хайж байдаг", гэв. Тэр бүүр гайхсан байв: "тэд хайгуулчид огт биш байна лээ", гэсэн. Тэгээд тэр Америкаас, Нью-Йоркоос зутгаад ирсэн. Эхний онгоцоор, 3 хоногийн дараа буцсан. Тэгэхээр, та бүхэн бүгд мэдэх хэрэгтэй (асар чухал). Та буруу багштай байна уу, цуг байна уу? Үүнийг бид танд хэлэх үүрэгтэй. Өчигдөрхөн л энд хүүхэд дагуулсан 2 эмэгтэй ирсэн. Тэр нэг эмэгтэй асуудалтай байсан. Нөгөө нь мөн адил асуудалтай тэгээд хүүхэд нь ярьж чадахгүй, хоолой нь хахчихсан байсан.. Тэгээд хүнийг шалгаад үзвэл, учирыг нь ойлгоно. Ямар ч сажаа йогчин үзээд, зүүн Свадистана, зүүн Агьяа хүрдэндээ халдвартай байна гэдгийг олж мэднэ. Зүүн Свадистана болон зүүн Агьяа нь зэрэг булгилах юмуу халуу шатаж байвал тухайн хүн эрх нь бүрэлдээгүй зөвшөөрөлгүй багш дээр очсоны тэмдэг юм. Үүнийг бид 'анадикар честа' гэдэг. Тэд багшлах ямар ч эрхгүй. Хэрвээ хүн тийм багштай байсан бол тэдний Кундалини нь хөдөлдөггүй. Кундалини нь хөдөлдөггүй, зүгээр л гацчихдаг. Хөдөллөө ч, буцаад сорогдоод уначихдаг. Буцаад сорогдоод хучин байдал руугаа унадаг.Та, тэр багшаа хүсч байна уу? Гэгээрэхийг хүсч байна уу? Энэ нь ГОЛ нь юм. Надтай маргах ямар хэрэг бнэ? Би тэгвэл таныг Оюуныг сэргээх боломжгүй. Энэ нь ойлгомжтой. Үүнд, ямар нэгэн мөнгө төлөх ямар ч хэрэггүй. Би танаас юу ч авахгүй. Үнэгүй хүртэцгээ. Магадгүй тэд хэлэх байх, манай нөхөр үүнд өөрийн мөнгөнөөс маш их зарцуулдаг. Тиймээс, би та бүхнээс юу ч авахгүй. Зөвхөн, таны төлөө, таны өөрийн ололт амжилтын төлөө хэлж байна. Буруу багштай холбоотой л байвал Кундалини чинь өгсөхгүй. Гэмтэл нь зүүн Свадистан, зүүн Агьяа-нд илэрдэг. Гэхдээ хүн өөрөө солиотой, согогтой болохоос нааш үүнийг мэддэггүй. Туйлын... Та шизо-той болно, та өөрөө мэдэхгүй Та ЭГО-той болно, та өөрөө мэдэхгүй. Яаж мэдэх билээ? Оюун чинь сэргээгүй юм чинь. Хүн Оюунаа сэргээхээс нааш, хүн бусдыг болон өөрийгөө мэдэрдэггүй. Харанхуй байдаг. Тэгээд хүн харанхуй бол, та юунд ч итгэлээ, та юу ч бодлоо, ХЭРВЭЭ ЭНЭ ЧИНЬ БУРУУ БАЙВАЛ би хэлэх үүрэгтэй, ШАЛТГААНЫГ нь Тэгээд (бүх зовлонгийн) хамгийн том шалтгаан нь бол буруу багшийг дагахад оршино. (Үгийг минь хүлээж ав.)

1987-1025, Diwali Puja, Power of Innocence (part)

View [online](#).

Diwali Puja, "Power of Innocence". Lecco (Italy), 25 October 1987.

Тэд будилаад... Юун түрүүнд бид, Шри Ганеша-д ёсолдог Яагаад гэвэл Шри Ганеша нь бидэн доторх "гэмгүй" ариун чанарын - эх үүсвэр юм. Үнэндээ, бид өөрсдийн дотоод ариун чанартаа ёслол байгаа юм. Тэгээд, энэ гэнэн ариун чанар нь та бүхнийг гэгээрүүлдэг (-ийг өгдөг). Би та бүхэнд өчигдөр хэлсэн, Гэрэл нь гэмгүй ариун чанартай. Гэхдээ энэ гэрэл нь ариун мөртлөө мэдлэг агуулдаггүй. Харин, та бүхний Гэрэл бол мэдлэг агуулсан "гэмгүй чанар" юм. Бид бодохдоо, мэдлэгтэй хүмүүс хэзээ ч гэнэн байдаггүй гэж ямагт боддог. хэзээ ч энгийн байдаггүй Тэгээд, гэнэн цайлган чанарын талаар бид бодохдоо, гэнэн цайлган хүн ямагт хохирч байдаг гэж боддог... мэхлүүлж байдаг ... тэгээд ямагт үл ойшоогддог гэж боддог. Гэтэл, гэнэн ариун чанар бол агуу их ХҮЧ юм. Энэ нь, таныг хамгаалдаг хүч юм Хүнд мэдлэгийн гэрэл өгдөг Бидэнд байдаг мэдлэг бол хүний ертөнцийнх... бусдыг хэрхэн ашиглах бусдыг хэрхэн мэхлэх хэрхэн тэднээс мөнгө салгах бусдыг хэрхэн дооглох бусдын дээр хэрхэн гарах талаарх мэдлэг байдаг. Харин гэнэн ариун чанарын гэрэл нь хамгаас дээд зүйл бол Хайр гэдгийг ухааруулдаг. Мөн энэ нь, бусдыг хэрхэн хайрлахыг заадаг, бусдыг хэрхэн халамжилах уу, бусдад хэрхэн зөөлөн хандах талаар сургадаг. Энэ нь мөн дотоод гэрэл өгдөг. Тэс эсрэг, энэ амьдралын "авидйа"- харанхуйгаас. Тэс эсрэг. Гаднах "авидйа" биднийг юу сургадаг вэ гэвэл өрсөлдөх, барьцах хүнийг хэрхэн доош нь дарах зүйлийг сургадаг.. Яагаад гэвэл энэ нь айдаг учир Энэ нь өөртөө итгэлгүй байдаг учир Энэ "харанхуйн" мэдлэг нь өөртөө ямар ч итгэлгүй байдаг Хэрвээ энэ нь өөртөө итгэлтэй байсан бол ингэж авирлахгүй байсан Харин гэнэн ариун чанарын гэрэл нь бүх зүйлийг мэддэг. Юунаас ч айдаггүй. Хүүхдүүдийг бид гэнэн ариун гэдэг Тэдэнд тийм ариун хүч байдаг Олон удаа анзаарахад, хүүхэд өндөрөөс унаад үхдэггүй. Харин том хүн амь нөхчдөг, илүү намхан газраас унаад хүртэл сүйрдэг Тэгээд хүүхэд унаахдаа огт айдаггүй зүгээр л баярладаг шүхрээр бууж байгаа мэт л баярлаж байдаг, сайхан... Унахдаа хүртэл босоод, зүгээр хүн бүр рүү хараад инээдэг Хүмүүс яагаад санаа зовоод байгааг нь ойлгодоггүй Учир нь тэр гэнэн байдалдаа өөрөө Түүнээс илүү агуу хүчинд халамжлуулж байдаг, хамгаалалгдаж байдаг гэдгээ мэддэг. Тэр, тийм нэг түүнээс илүү дээгүүр хүч байдаг гэдгийг мэддэг. өөрөө санаа зовох хэрэггүй гэдгийг мэддэг. Гэтэл бид хүүхдэд янз бүрийн зүйл толгойнд нь хийж байдаг Ийм маягаар хүүхэд гэнэн ариун чанараа алдаж эхэлдэг. Тэгээд хулчгар болдог, муу бодолтой хүн болдог. Шудрага бус хүн болдог Гэхдээ л хүмүүс, хүүхдийг юм мэддэггүй учир тийм гэнэн байгаа гэдэг. Нэг талаас нь авбал... Яагаад гэвэл амьдрал мэддэггүй учир, гэдэг. Гэхдээ, гэнэн ариун чанарын гэрэл нь бол бүх аюулыг мэддэг. Мөн үүнээс яаж салахыг мэддэг. Мөн аюултай хүнээс хол байхаа мэддэг. Нэг ухаантай хүн байж, тэр шатаар явж байжээ. Мөн тэнэг хүн нөгөө талаас нь явж байж. Ухаангүй хүн Ухаангүй хүмүүс ямагт түрэмгий байдаг, тийм байдаг. Дутуу гэдгээ мэддэг учираас.. Тэгээд тэр ухаангүй хүн өөдөөс нь явж байгаа хүнд Нэг нь зам тавих шаардлагатай байж... Тэгээд тэр: "Би мангаруудад зам тавьдаггүй", гэж тэр ухаангүй нь хэлж Харин гэтэл тэр ухаантай нь, "би тавьдаг" гээд түүнд зам тавьж өгч. Ийм маягаар, ариун чанарын гэрэл нь, хүнтэй харьцахдаа хэр хэтрэхгүй байх, хүнтэй хэрхэн ярих, нөгөө хүний зан авир, асуудалд нь орооцолдох үгүйг мэдүүлдэг. Өөрөөр бол8 зам тавин холддог. Зүйлийг мэддэг... Энэ хүн ухаангүй тэнэг учир, би түүнд зам тавьж, орхиё гэдэг. Тийм хүнд тэгж их анхаарлаа хандуулдаггүй Тийм хүнийг тэр тоодоггүй... Энэ бол гэнэн ариуны Гэрэл юм. Энэ нь хүнд ялгах салгах ухаан өгдөг. Бусадтай хэр хэтрэхгүй байх.. "Би тэр хүнд хайртай" гэдэг Гэтэл, нөгөө (хайртай гэх) хүн нь таныг өшиглөн, зодон, зовоож туйлын аймшигтай шүглэсэн байлаа ч та тэр хүнд ухаангүй дурлаад байвал... өөрийгөө хүндлэх гэсэн ямар ч зүйлгүй Энэ зүйл нь хүн ямар ч ... Та гэмгүй цайлган хүн байж болно амьдралын өнцгөөс авбал. Гэхдээ, гэгээрсэн гэнэн биш Хэрвээ та гэгээрсэн гэнэн хүн бол таны гэнэн чанар чинь хүч болдог. Энэ нь юун түрүүнд танд ялгах салгах ухаан өгдөг. Жишээ нь, та харанхуйд гэрэл бариад явбал та могой юу, олс уу гэдгийг мэднэ. Харин ямар ч гэрэлгүй явбал, та (харанхуйд) харж чадахгүй. Гэлээ ч, жишээ нь, могой ирэхэд, хүн зугтдаг Харин жишээ нь, ухаангүй тэнэг хүн бол: "намайг хатга, хатга" гэдэг. "Хатгахаар яадагийг нь харья", гэдэг Хүүхдүүд... Гэхдээ, хэрвээ та гэгээрсэн хүн бол та могойд: "надаас хол байгаарай" гэнэ. "Баяртай" гэдэг... Мөн могой үүнийг нь мэдээд яваад өгнө. Эсвэл, могой нь хөнөөлтэй муу могой бол та харж мэдээд зугтахдаа бодно... Энэ гэнэн ухааны хүч нь бол маш чухал зүйл юм. Тэгээд энэ нь хүнд гэгээрсэн үед л зөвхөн илэрдэг. Тэгэхлээр, бид жишээ нь харанхуй/мэдлэггүй түвшинд байлаа гэвэл, мөн тэгээд гэнэн байвал, гэнэн ба харанхуй бол хүн гэнэн ч биш, харанхуй ч биш болдог. Ямар ч гэгээрэл, оюунгүй, Тиймээс, башир болдог. Хэрвээ тэдэнд аль аль чанар нь байхгүй бол харанхуй биш байлаа ч, (хүний түвшний) юм мэддэг ч бүх зүйлд мундаг тэд олны дунд хурц тод ухаантай мундаг мэдлэгтэй хүмүүс гэж тооцогддог

байлаа ч, тийм хүмүүсийг хүмүүс мэдлэгтэй хүн гэж тооцдог, хүний ертөнцөд Гэвч, тэдэнд гэнэн ариун чанар байдаггүй, тэгээд тэд бүх зүйлийг шулуутган бүдүүвчилж эхэлдэг. Гэтэл, тийм бодлыг хянан удирддаг тэр гэнэн ариун ухаан нь алдагдан арилдаг. Яагаад гэвэл тэд гэнэн ариун байхыг тэнэг гэж боддог. Үүнийг үнэлдэггүй. Тэгээд тэд бусдыг мэхлэж, аргалж эхэлдэг Хэрцгий авирлаж, хөнөөлтэй зүйл хийж, уйваагүй, ёжтой ярьж эхэлдэг. Эдгээр бүх зүйл нь тархийг ажиллуулж эхэлдэг. Яагаад гэвэл буцаад гэнэн ариун байдалдаа орч чадахгүй болохоор Хүн тийм хүнд дургүй болдог, эцэст нь.. хажуудаа хүсдэггүй. Тэгээд тэд их юм бодож эхэлдэг, бид мундаг дээгүүр, сонгогдсон хүмүүс, бусдаас илүү... Тийм бодолтой болж эхэлдэг. Тэгээд хоорондоо санаа нэгддэг Тэгээд харанхуйг мэдлэг гэж тооцон хүлээн авдаг. Дотроо бол бүрэн харанхуй, гаднаа бол мэдлэгтэй мэт. Ийм маягаар, гаднаа нэмэгдээд л, нэмэгдээд л.... Тэд өөрсдийн үнэн байдлаа мэдэхийг ч хүсдэггүй дотоод байдлаа Гаднах зүйлийг мэдлэг гээд, сэтгэл ханачихсан үүндээ үргэлжилсээр тэгээд толгой нь гэмтэхээр, "Өө Бурхан минь" гэдэг юу вэ? гээд ухаардаг. дотор минь бүхэлдээ харанхуй байна шүү дээ, гэдэг Бүх цонхоо хаагаад бид шавьж шиг амьдрах боломжгүй, гадна нь нар гэрэлтэж байхад. Бид дотроосоо гэрэлтэй болох ёстой Өөрсдөө харах нүдтэй болох хэрэгтэй Бид хэн бэ? Бидний чадавх юу билээ? Хэр хол бид хүрэх вэ? Хэр сайжирч байна? өөрсдөө, амьдралдаа, зорилгоо хэрхэн боловсруулж байна? Тэгэхлээр, гэрэл гэгээ нь эдгээр лаа, дэнлүү шиг дотроос чинь илрэнэ. Энэ нь долгионоор = "чайтаньяа" = гэрлээр илэрнэ. "Чайтаньяа" нь тэр чигээрээ гэрэл юм. Гэхдээ, энэ гэрэл, тэр 'гэрэл' хоорондын ялгаа нь энэ нь, зөвхөн нүдэнд харагдах зүйлийг л мэдүүлнэ. Энэ нь танд энэ бол чулуу, энэ бол мод энэ бол байшин эсвэл хүний нүүр байна зэргийг харуулна.... энэ амьдралын гэрэл нь... Гэхдээ танд хэлж чадахгүй зүйл бол энэ хүн сайн хүн үү, муу хүн үү гэдгийг хэлэхгүй. Энэ байр "долгион"-той бна уу, сөрөг бна уу? ээлтэй юу, үгүйг хэлэхгүй Энэ нь танд ээлтэй, ивээлтэйн хүчийг өгдөггүй. Бид энд, Ганеш-ийн гэнэн ариуныг ярьж байна. Энэ нь бидэнд ээлтэй, эерэг байх ухааныг өгдөг мөн өөрсдийг минь ээлтэй эерэг болгодог. Иймээс, "чайтаньяа" нь хүнийг гэгээрүүлдэг тэр гэрэл нь юм. "Чайтаньяа" нь өөрөө гэгээрэл юм. Чайтаньяа нь танд хамаатай өөрийн бүх мэдлэгээсээ өгдөг. Төсөөлөхөд хүртэл маш нарийн зохицуулалттай Эдгээр "чайтаниа" нь, жижигхээн бөөрөнхий цагираганууд мэт байдаг, маш жижиг, жижиг Эдгээр нь, оюун ухаан агуулдаг, ялгаж салгах ухаан нь тэдэнд суулгаастай байдаг тухайн хүнд энэ нь сайн хүн үү, муу хүн үү гэдгийг хэлж өгдөг. Та бүхэн сажаа йога-г маш хялбархан олсон тиймээс, та бүхний компьютер ямар өгөгдөлтэйг мэдээгүй. Энэ чинь мэдлэг агуулдаг. Үүнийг нь мэдвэл, зөвхөн сайн хүн үү, муу хүн үү гэдгийг хэлэхээс гадна, мөн ямар асуудалтай хүн бэ гэдгийг мэдүүлдэг. Жишээ нь, энэ гэрэл зөвхөн 1 хэмжигдэхүүнд, хүн яаж харагддагийг үзүүлдэг яаж явдаг зэргийг харуулдаг. Хэрвээ та, ямар нэгэн зүйлийг төсөөлж эхэлвэл, төсөөлж эхэлвэл... "Надаа ийм санагдаж байна", "Би ингэж бодож байна" гээд байвал (зүгээр үү?) Та бүхэн намайг сонсохгүй байгаа юм уу? Аан? Юу гэнээ? Өөр өрөөнд, хүүхэдтэй эхчүүд таныг видео-гоор үзэж байгаа, тэд таныг сонсохгүй байна гэнэ. Дээд давхарт Би сонссонгүй. Юу болсон юм? Дээр хүүхдийн өрөө байгаа, тэд таныг үзэж байгаа, гэхдээ сонсохгүй байна гэнэ. Өө, тийм үү? Гэхдээ хүүхдүүд энд байна шүү дээ Нялх хүүхдүүдтэй эх нар Өө, Бурхан, нэг хүн очоод засах хэрэгтэй юм биш үү? Өмнө нь та бүхэн шалгаж үзэх хэрэгтэй байж. За яахав.. Тэгэхлээр, бидэн дотор сэргэсэн "чайтаньяа" нь биднээр урсан ялгарч, мөн бид үүнийг энд тэндээс хүлээж авдаг бүхний нэвтрэн урсдаг бүх атом зүйл, молекулд булиглаж байдаг. Энэ нь бидэнд оюун мэдлэг өгдөг. бүх эд зүйлийн талаар, бүх амьд амьтдын талаар, хүн бүрийн талаар..... мөн бүх Бурхдын талаар мэдлэг өгдөг. Энэ гэрэл үгүй бол та бүхэн намайг танихгүй байх байсан. Ямар ч Бурхныг мэдэхгүй байх байсан. Өөрсдийн амьдралын байр суурь, амьдралын зорилгоо мэдэхгүй байх байсан. Та бүхэн яагаад амьдарч буйгаа мэдэхгүй байх байсан, яагаад энд байгааг мэдэхгүй байх байсан. Та бүхэн энд зүгээр мөнгө хурааж, даатгалд өгч, хадгалахаар ирсэн гэж үү? Одоо хэн ч тэгэхгүй. Нэг байртай болоод эхнэрийнхээ хуруун доор гүйх гэж ирсэн гэж үү? Эсвэл эхнэр нь ч нөхрийн үгээр байх гэж төрсөн гэж үү? Ямар нэг байдлаар хүүхдээ өсгөөд... тэгээд л болоо гэж үү? Энэ "чайтаньяа" нь маш тодорхой "ҮГҮЙ" ээ гэнэ. Хэрвээ та бүхэн, эдгээр бүх зүйлд орооцолдоод байвал тэгээд нийтээс бүхэлдээ тасрах юм бол, бүх даяар нийтээс тасарвал энэ Гэрэл нь унтран арилдаг. Энэ Гэрлээс тасрангуут та бүхэн ямар ч Гэрэл авах боломжгүй болно.. Яаж ч холбогдлоо, ямар ч энергийн "долгион"-той байлаа, холбоо нь маш бат бөх байх ёстой. Туйлын нягт, бүрэн тогтвортой холбоотой байх ёстой. Жишээлбэл, нэг асч унтардаг тогтворгүй гэрэл байвал та зүйлсийг бүрэн сайн ойлгож чадахгүй. Энэ "долгион" нь бүх зүйлийг мэддэг байлаа ч... ажилладаггүй муу төхөөрөмжтэй бол мэдлэг (гэрлээ) хэрхэн хүргэх билээ? "Долгион"-г үнэлдэггүй, ойшоодоггүй бол, "долгион"-той оюунтай харьцдаггүй бол.... яах билээ? Хүүхдийг аваад гар, хүүхдийг хүчлэх хэрэггүй, хүүхдүүдэд тэвчээр алдах хэрэггүй, нэг зүйл хүссэн учир л уйлж байгаа шүү дээ....

1988-0110, Makar Sankranti/Shri Surya Puja (part)

[View online.](#)

Makar Sankranti – Shri Surya Puja. India Tour, Bombay (India), 10 January 1988.

Бүх хөгжил хувьслын явцад газар Эх нь (өөрийн тэнхлэгийн хүчээр) маш их үүрэг гүйцэтгэсэн. Үүнтэй адил хүн доторх гол тэнхлэг бол маш чухал. Амьдралын гол зарчим (зүй тогтоол) бол бидний тэнхлэг юм. Бид өөрсдийн (төв, гол) тэнхлэгээ баримтлах ёстой. Тэнхлэгээсээ хазайсан хүмүүс нь, нэг бол зүүн тал руу эсвэл баруун тал руу орсон хүмүүс, бүрэн устгагдах боломжтой. Хэт их баруун талын эсвэл хэт их зүүн талын туйлширлаар устгагддаг. Тиймээс бид өөрсдийн төв тэнхлэгээ сайтар анхаарах ёстой. Төв тэнхлэгээ сайн хөгжүүлээгүй хүмүүс төрөл бүрийн хүрдний, төрөл бүрийн чанар бүхийн асуудалтай байдаг. Төв тэнхлэгээ хэт их хүчилдэг хүмүүс толгойгоо гэдийсэн байдаг. Маш их баруун тийш туйлширсан хүн байх бөгөөд ЭГО-ны асуудалтай байдаг. Харин толгойгоо бүүр доошоо тонгойсон, боол мэт хүн мөн өөрийн хөнөөл рүү чиглэсэн хүн байдаг. Тэгээд энэ хоёр янзын хүмүүсийн хооронд маш их асуудал байдаг. Нэг нь нөгөөгөө дарангуйлахыг тэмүүлдэг. Тэгээд хүнийг дарангуйлаад эхлэхээр, үнэндээ бол тэд дарангуйлж буй хүнээс гадна, мөн өөрсдийгөө устгаж эхэлдэг. Жишээлбэл, бид харсан, (өнгөрсөн зуунд) Англичууд энд ирээд биднийг эзэгнэсэн. Мөн Францууд өөр газар очоод өөр хүмүүсд ноёрхсон. Мөн Португальчууд өөр улсуудыг эзэгнэж байсан. Гэхдээ бүх тэр дарангуйлах, эзэгнэх зүйлсүүд давхар хариутай байдаг. Юун түрүүнд, жишээ нь тэдний дарангуйллаар Энэтхэгчүүд маш боол мэт зантай болсон. Энэтхэгчүүд туйлын боол мэт болчихсон, өнөө хүртэл хүнд байх ёстой биеэ даасан тэнхлэгээ (нуруугаа) алдсан. Тэд туйлын боол мэт. Ялангуяа Энэтхэгчүүд нутгаасаа яваад, баруунд очоод тэд туйлын зарц мэт байдаг. Тэд төрөл бүрийн боол мэт зан гарган, цагаан арьстай хүмүүсийн таалалд багтахыг хичээдэг. Цагаан арьстай хүн Энэтхэгт маш биширмээр зүйл нь болчихсон. Энэ нь цагаан арьстай хүмүүсийг бүүр хөөргөн ЭГО-нд нэмэрлэхсэн. Энэ нь цагаан хүмүүсийн ЭГО-г хөөргөн, өдгөө юу болж буйг харвал, тэр их ЭГО нь тэднийг сүйрүүлж байна. Тэд ЭГО-ныхоо улмаас мөхөлийн, устгалын ирмэгт ирсэн. Энэ бол маш энгийн бус, маш өнгөц, гаднах зүйл Хүн ойлгох хэрэгтэй. Хүнд байдаг хамгийн дээд (үнэ цэнэ) нь бол – гол тэнхлэг нь юм. Хүн бүр гол тэнхлэгтэй. Хүн бүр бусдын тэнхлэгийг хүндлэх ёстой. Сахажа йога-нд би та бүхнийг нүүрээр чинь тэгж их танихгүй. Та бүхнийг би хүрдээр чинь, төв суваг Сушумнагаар чинь, ямар байгаагаар нь танидаг. Хэрвээ таны Сушумна гүнзгий бол би таныг гүн хүн гэдгийг мэднэ Хэрвээ та өнгөц, хуурамч Сушумна-тай бол би таныг маш өнгөц, хуурамч Сушумна-тай хүн гэдгээр танина. Хичнээн, та ямар нэг сайхан аальтай, сайн юм хийлээ ч, эсвэл Сахажа йогийн талаар ярин, Сахажа йогийн талаар маш их зүйлийг мэддэг байлаа ч Тэгээд энгийн хүн гайхширмаар агуу их зүйлийг Сахажа йогийн мастер мэт ярилаа ч би таныг, хэр гүн хүн вэ, гэдгийг мэднэ. Тэгэхлээр, тэнхлэг голдоо гүн гүнзгий байх нь юу юунаас илүү чухал юм. Төв тэнхлэг чинь маш гүнзгий байх ёстой. "Төв тэнхлэг нь ялгаагүй, адилхан шүү дээ", гэж та хэлж болно. "Яаж гүн байх юм?" гэдэг... Тэгэхлээр, төв тэнхлэг нь хүн дотор 3 бүхэл 1/2 хуулиастай цаасан ороомог мэт байдаг. Тэгээд үүн дотор нь "Брахма Нади" байдаг. "Брахма Нади" нь маш нарийн, мяндсан үс шиг байдаг. Үс шиг тийм нарийн Кундалини нь үүгээр нэвтрэн урсдаг. Харин хэрвээ хүн гүнзгий бол тэр "Брахма Нади" нь илүү өргөн урсгалтай бөгөөд гаднах ороосон сувгууд нь илүү бага байдаг. Гүнзгий биш хүмүүсийн гаднах сувгууд нь, гаднах давхрагууд нь илүү их байдаг бөгөөд дотроох гол нь харин нарийхан байдаг. Тийм хүмүүс гадна маш эрч хүчтэй, маш ухаантай, овсгоотой харагддаг, маш сайхан харагдаж, ямар ч сайхан санагдаж болно. Гаднаа. Харин дотроо бол тэд гүнзгий биш байдаг. Хэрвээ тэд дотроосоо гүнзгий бол тэдний бүх хандлага үзэсгэлэнтэй. Тэд хүнийг маш баярлуулдаг хүмүүс. Тэд маш их баяр хүрмээр. Тэгээд дээр нь, өөр хүмүүстэй та тааралдах юм бол, тэд маш баяртай харагдах боловч, таныг баярлуулахыг хүсвч Тэр баяр нь тийм үнэхээр гүн гүнзгий биш. Зүгээр жинхэн баярыг устгадаг л зүйл байдаг. Тиймээс, бид өөрсдийн төв тэнхлэгээ илүү гүнзгий болгох нь чухал юм. Энд бид, хүчин зүтгэл дутагдаж байгаа юм. Шаардлагатай идэвх чармайлт нь дутагдана. Зарим хүмүүс төрөлхийн маш гүн гүнзгий тэнхлэгтэй байдаг. Зарим хүмүүс нь маш давчуу, хумигдсан маягийн тэнхлэгтэй байдаг Энэ тэнхлэгийг тэлэх, хөгжүүлэх хэрэгтэй Жишээ нь, та бүхэн миний пүжа-нд ирэхэд би урсгалыг чинь нэмэгдүүлдэг, үнэн. Гэхдээ энэ нь түр зуурхан тогтдог. Тэр хэмжээнд нь тогтоохын тулд та гэртээ ажиллах хэрэгтэй, мөн хамт олны дунд мөн адил, гэхдээ гэртээ маш их засал хийж бясалгах хэрэгтэй. Гэхдээ үүнийг үнэнээсээ хийх хэрэгтэй. Зүгээр нэг тоглоом шиг авах хэрэггүй. Өнгөцхөн, хөнгөн хийсвэр, ухаангүй хандах ёсгүй. Үүнийг маш чухавчилж, маш чухал үүрэг хүлээсэн гэдгээ ухамсарлах хэрэгтэй. Энэ нь гүнзгий бясалгалын зүйл, Бурханд залбирах, Бурханд хандах зүйл гэдгийг ойлгох хэрэгтэй. Тийм бишрэл, хүндэтгэлтэйгээр хийх ёстой зүйл юм. Яагаад гэвэл тэр (бишрэл) хүндэтгэл нь тэрхүү ... хүрэх ололтын түлхүүр нь юм. Хэрвээ хүн өөртөө

ямар ч хүндэтгэлгүй бол мөн бусдыг огт хүндэлдэггүй бол - энэ бүтэхгүй. Юун түрүүнд, өөрийн амьдралдаа хүндэтгэлтэй байх хэрэгтэй. Би өөрийн амьдралаа юу болгож байна?, Юунд үрж байна? Яагаад үрээд байна? Гүнзгий байх ямар хэрэгтэй юм? Эцсийн эцэст би учиртай л төрсөн байх.. Би өөрийн ирсэн зорилгоо дүүргэж байна уу? Эдгээр бүх зүйлс толгойнд чинь ороод ирвэл өөрийн ЭГО-г ялан гарах нь маш хялбар болно. Учир нь, хүмүүс жижиг, жижиг зүйлс дээр тэмцэлдэж байдаг. Сахажа йоганд би харсан, маш утгагүй, хэрэггүй зүйлс дээр тэмцэлдэж байдаг. Маш хэрэггүй. Миний хувьд энэ маш ухаангүй санагддаг. Тиймхэн юмнаас болоод зөрчилддөг гэдгийг хэлэхэд хүртэл утгагүй санагддаг. Харин гүнзгий хүн бол юу ч яридаггүй байлаа ч, бусдын нүдэнд тэгж (их гайхагдаж) харагдадгүй байлаа ч, эхний эгнээнд сууддаггүй ч тийм хүн өөрийн гүн гүнзгийгээрээ илэрдэг. Учир нь би тийм хүнээр илүү их урсах боломжтой байдаг.. Үүнд хүрэхийн тулд хүн бясалгах хэрэгтэй. Бясалгах нь маш чухал. Өдөр бүр. Өдөр бүр. Өдөр бүр. Та хоолоо нэг өдөр идэхгүй байж болно. Нэг өдөр унтахгүй байж болно. Нэг өдөр ажилдаа явахгүй байж болно. Өдөр бүр хийдэг юугаа ч хийхгүй байж болно. Гэхдээ өдөр бүр бясалгах ёстой. Энэ бол маш чухал. Тэр төв, голын хавчиг сувгыг тэлж нэгдүүлэхийн тулд - энэ бол маш чухал зүйл юм. За, тэгээд энэ зүйл нь танд болон, хөгжин нээгдэж эхэлвэл юун түрүүнд, өөрийгөө анзаарвал, биеийн тав тухыг та тоохоо болино. ямар нэгэн эд зүйлийг сонирхохоо болино. Юу ч байлаа, та тоохоо болино. Ангид болно. Үүнд толгойгоо зовоохгүй. "Тэг, тэг", гээд орхино. Өөрөө зүйлээс хамаарч, зууралдахаа байна. Үүнээс зүгээр салаад, "Өө, Бурхан минь, энэ арай ч биш юм, орхиё", л гэдэг. Тэгээд, таны бүх анхаарал одоо дотогш болно. Анхаарал чинь дотогшоогоо ороод ирвэл, энэ нь илүү их тэлж эхэлдэг Тэр "Брахма Нади" гэдэг тэр төв голын хэсэг нь тэлэн өргөжин, уужирч эхэлнэ. Жижиг жижиг зүйл дээр ч гэсэн, жишээ нь би нэг хүнийг талаар ярилгүй, нөгөө хүний талаар ярьчихвал, "Өө, Эх минь, яагаад миний нэрийг хэлсэнгүй вэ?" гэдэг Энэ чинь, маш өчүүхэн, чухал биш, ямар ч хамаагүй зүйл шүү дээ. Гүн гүнзгий/өргөн тэнхлэгтэй л бол, та надтай хамт, би таньтай үнэмлэхгүй нэг хамтдаа холбоотой байна. Гэтэл, тэр гаднах зүйлд автаад, "Өө, Эх тэр хүнд сари өгчихлөө, надаа сари өгөөгүй"....."Тэгээгүй, ингээгүй..." гээд байвал... Энэ бүх зүйлс толгойнд чинь орж байвал, та дотроо үнэхээр, ямар нэг дутагдалтай байна. Эсвэл гомдол тоочин, "би тийш явах хэрэгтэй болоод, автобусаар, зогсоогоороо явсан"... Энэ чинь таныг, дотроосоо уужуу биш байдалтайг чинь харуулна Энэ уужруулдаг зүйл нь таныг дотроос чинь тав тухтай болгодог. Тэр зүйл таныг үнэхээр, маш тав тухтай болгодог, ямар ч нөхцөлд, ямар ч байр сууринд, ямар ч амьдралын хэв маягт... Тэгээд та бусад өөр юуг ч тэгж хүсэхээ байна. Үүнд та хүрэх хэрэгтэй өөрийн бясалгалын зүтгэлээр. Хоёр дугаарт, Сахажа йога нь өнөөдөр хамтын/нийтийн үйл гэдгийг мэдэх хэрэгтэй Би харахад, ялангуяа Энэтхэг эрчүүд, тэд хэзээ ч гараараа ажилладаггүй. Энэ буруу юм. Яагаад гэвэл гараараа огт үйлдэдгүй. Тэдний хамт олны байдал маш муу. Энэтхэгчүүд хамгийн муу нэгдэлтэй. Жишээ нь, ашрам хамтын байрны хувьд, хэн ч тэнд амьдрахгүй юм чинь, барих ч хэрэггүй Тэд өөрсдийн хувийн байртай болохыг хүсдэг, өөрсдийн гэр бүл, өөрсдийн хүүхэд гээд... Тэд хамтрах хүчний хувьд хамгийн муу Шалтгаан нь, Энэтхэг эрчүүд хэзээ ч гараараа юм хийдэггүй. Тэд ганц ч хадаас зоож чаддаггүй. Ихэнх нь. Юм засах, юу ч хийдэггүй. Тэд зүгээр ташаагаа тулж зогсоод, бусад хүмүүсийг л "Ажил!" гэж байдаг. Марати хэлээр маш сонирхолтой зүйрлэсэн байдаг "...". "Тэмээн дээр суугаад, ямаа хариулах" гэсэн утгатай. Энэ бол Энэтхэг эрчүүдийн онцлог юм. Тэд юу ч засаж янзалж чаддаггүй. Юу ч хийж чаддаггүй. Жишээлбэл, энд нэг хүн нэг юм хийж байвал, тэд хажууд нь ингээд л (ташаагаа тулаад), хараад л зогсож байдаг. Хэзээ ч тусалдаггүй. Сахажа йогч бүрийн хувьд "Шрамадан" гэдэг зүйл маш чухал. Та бүхэн бүгд "Шрамадан" үзүүлэх хэрэгтэй. "Шрамадан" гэж ямар нэгэн ажил хийхийг хэлж байгаа юм. Энэ зүйл бидэнд дутагдалтай. Юу ч байлаа хий, гэрээ ч цэвэрлэж болно. Гэрийнхээ гадаг цэвэрлэ. Эсвэл гадна талаа цэцэрлэгжүүл. Ханаа буд. Юу ч хамаагүй хий. Гараа хөдөлгө. Хэрвээ хийх юм, юу ч байхгүй бол, үсээ самнах юм уу, тиймэрхүү юм хий. Хамгийн хялбар гэж санагдсанаа хийж эхэл. Яагаад гэвэл тэд үүнийг ч хүртэл хийдэггүй. Тэд сахлаа ч хусдаггүй. Үйлчилэх хүн дээр очдог. Тэд туйлын үнэмлэхгүй залхуу хүмүүс. Харин Барууны орнуудад хүмүүс эсрэгээрээ гараараа их юм хийдэг. Тийм улмаас, тэд гараараа юм хийдэг учир, тэд маш хамт олонч. Тиймээс тэд үүн дээр илүү их оноо авч байгаа юм. Харин Энэтхэгчүүд нөгөө талаас уламжилтай учир, Кундалини, Ганеша, бүх зүйлийн талаар мэддэг учир үүгээр, оноогоор давуу байдаг.

1988-0618, Seminar Day 1, Introspection and Meditation

[View online.](#)

Advice, "Introspection and Meditation". Shudy Camps (UK), 18 June 1988.

Энэ жил бид олон нийтэд зориулсан, шинэ хүмүүст зориулсан хичээл явуулахгүй (Англид). Яагаад гэвэл тодорхой нөхцөл байдалд байгаа учир. Хаана ч бай, ямар нэгэн нөхцөл байдалд орсон бол бидний хичээлд нөлөөлж, өөрчилж байвал бид нэн даруй мэдэх хэрэгтэй, тэр бүх өөрчлөлтүүдийн цаана, ямар нэгэн шалтаг, зорилго байгааг мэдэх хэрэгтэй. Тэгээд бид, тэр байдлыг шууд хүлээж ойлгох хэрэгтэй. Сэтгэл зүрхээ нээлттэйгээр хүлээж авах хэрэгтэй. Бурхан/Тэнгэр бидний өөрчлөхийг хүсч буй нь тэр. Жишээ нь, би замаар явж байхад хүмүүс Эх минь, бид төөрчихлөө гэвэл, би: "зүгээр ээ" гэдэг. Яагаад гэвэл би хэзээ ч өөрөөсөө төөрдөггүй. Гэхдээ би яг тухайн замаар явах шаардлагатай байсан учир тэр юм. Үүгээр явах хэрэгтэй байсан юм. Тиймээс би тэр замаар явалгүй "төөрч", энэ замаар явж байгаа юм. Хэрвээ та бүхэн тийм ойлголттой болвол зүрхэндээ тийм хангалуун болвол энэ амьдрал, та бүхний бодсоноос илүү агуу гэдгийг мэдэх болно. Одоогийн байгаа байдлаар бол, шалтгаан нь юу юм бол, гэж би бодсон. Шинэ хүмүүст зориулж хичээл явуулна гэж шийдсэн шалтгаан нь. Энэ жил гарцаагүй бид шинэ хүмүүст зориулсан хичээл явуулах боломжгүй. Шалтгаан нь бол бид өөрсдөө тогтворжиж, батжих хэрэгтэй-д байгаа юм. Ургаж буй амьд мод нь ургаж байх явцад нь (олон зүйл) тохиолддог. Тодорхой зүг чигт ургаж байсан бол өөрөөр хөдлөх шаардлага гардаг, яагаад гэвэл тэнд нь нар тусахаа байх ч юм уу усны түвшин хүрэхээ байх тохиолдолд ч юм уу өөрөөр хөдлөх шаардлага гардаг. Тэгээд тэд (ургах аргаа) өөрчилж эхэлдэг. Үүнтэй адил, бид Бурхан Тэнгэрийн нөлөөнд, гарт нь буйгаа мэдэх хэрэгтэй. Хэрвээ төлөвлөгөөнд, ямар нэгэн өөрчлөлт гарч байвал энэ нь буцаад бидэнд нөлөөлж байдаг учир бид ямар учиртайг олох хэрэгтэй. Энэ, "яагаад" гэсэн учир нь бол, бид гүнзгийрч батжих хэрэгтэй-д оршино. Сахажа йогчидын хувьд батжин тогтворжих нь маш чухал юм. Тогтворжуулж (сайжруулах) эхний алхам бол өөрсдийн дотоод байдлаа харах. Та бүхэн дотогшоогоо харах хэрэгтэй. Дотогшоогоо гэрэл тусгаад өөрийн бодит байдлаа хар. Сахажа йогт ирээд юунд хүрсэн, юу хийсэн байна? Хаана байгаад, хэр хол явсан байна мөн цааш хэр хол явах хэрэгтэй буйг хар. Танд дутагдаад байгаа тэр зүйл нь юу байна? Өөрийгөө хараад ирвэл гайхах болно, бодит байдалд нь хар, шүүж буруутгах хэрэггүй. муу хүчийг бүү буруутга, дотроо байгаа бохирдлоо зэмлээд хэрэггүй. Бусдыг ч бүү буруутга. Өөрийгөө л харж эхэлвэл. Юу нь буруу явчихсан байна, яагаад өөрийгөө гүйцэд тогтворжуулж чадахгүй байна? Та бүхэн хараад гайхна. Ямар нэгэн асуудал өөдий хүртэл байсаар л байсныг олно. Үүнийгээ засах хэрэгтэй. Эдгээр асуудлыг бид маш тодорхой харах боломжтой. Гэрлийн тусгалд та бүхэн эдгээрээ маш тод харна. Энэ нь намайг буруу явуулаад байна гэдгийг харах болно. Миний анзаарсан, хамгийн их гайхширтай зүйл бол Сахажа йога нь ямагт, ямар нэгэн маяа (төөрөлдөл)-р бүрхэгдсэн байна. Тэгээд энэ маяа нь бол харанхуйн байдал юм. Заримдаа бүхэл бүрэн харанхуй, заримдаа хагас харанхуй.. Сахажа йогт ирээд та бүхэн ерөөгддөг. Та өөрөө ерөөгддөг, магадгүй гэр бүлийн хүмүүс чинь мөн ерөөгдсөн байгаа, хүүхдүүд чинь ерөөгддөг, бие махбодийн түвшинд ямар нэгэн ерөөл хүртдэг. Мөн санхүүгийн тал дээр та бүхэн ажилтай болдог, мөнгөтэй болдог. Та ямар нэгэн онцгой зүйлсээр ерөөгддөг. Энэ бол үнэндээ гайхамшигтай юм. Гэтэл хүмүүс эдгээр бүх олсон зүйлдээ маш их төөрөлддөг. Тэгээд гулсан унаж эхэлдэг. "Өө, бид ийм их ерөөлтэй болсон, одоо өөр юм хийгээд байх хэрэггүй болсон" гэж боддог. Хийсэн юм бүхнийхээ төлөө хангалттай ерөөгдлөө гэж боддог. Тийм биш юм. Энэ бол зүгээр нэг, та нарт үзүүлэх дэмжлэг байгаа юм. Та бүхнийг сахажа йогт бүрэн итгэлтэй болж тогтворжуулах гэсэн зүйл юм. Ялангуяа, та бүхэн намайг мэдэх хэрэгтэй, намайг хэн гэдгийг. Харин та бүхэн үргэлжлүүлээд унаад явах юм бол, магадгүй эдгээр ерөөл чинь эсрэг нөлөөтэй болох байх. Тэгээд магадгүй танд, "ямар хараал бидэнд таарчих ваа?" гэж санагдах байх. "Яаж яваад буруу зам руу орчих воо?" гэж бодох байх. Зарим хүмүүст энэ нь хэсэг хугацаа авдаг. Ерөөлийн оршихуй руу орсон гэдгээ өөрөө мэдэрдэг болтол нь хэсэг хугацаа болдог. Жишээ нь, орчин үеийн ихэнх төсөөллөөр бол бид, их мөнгөтэй болох нь хамгийн их ерөөл гэж боддог. Үүнийг мөн их ч хүмүүс хүртдэг. Гэхдээ үнэндээ бол энэ нь (ерөөл) биш юм. Өөрийн дотоод амар амгалангаа олох, гэрчийн түвшиндээ хүрэх, өөрийн долгион, урсгалаа сайн буйг нь мэдэрч, ямагт төв тэнцвэрдээ тогтож, дээшээ өгсөж байх нь ЖИНХЭН ерөөл юм. Яагаад гэвэл ҮҮНИЙ УЛМААС та бусад бүх зүйлийг хүртэх учир. Бүрэн төгс бүрэлдэл нь зөвхөн - та өөрөө дотроо бүрэн баяр баясгалантай болоход илрэнэ. Эцсийн эцэст, бүх зүйл нь зүгээр л - баяр жаргалд хүрэх шалтгаан нь юм шүү дээ. Энэ бол эцсийн төгсгөл биш. Хэрвээ тийм байсан бол тэдгээр мөнгөтэй хүмүүс, тэдгээр эрүүл биетэй хүмүүс нь, бүхий л ололт амжилтаар дүүрэн хүмүүс жаргалтай, амгалан байх байсан. Гэтэл тэд тийм биш байна. Тэд зовж байна. Тэд хэтэрхий их зовж байна. Тэгээд мөн тэд нэг

хэлбэрээр, өөрсдийгөө устгаж байна. Өдөр тутам. Яагаад гэвэл тэд амьдралаа үзэн яддаг, тэсдэггүй. Тэд, энэ амьдралд яагаад буйгаа ойлгодоггүй. Тэгэхлээр, эдгээр таны хүртсэн бүх ерөөл өөрт чинь учирах бүх өөрчлөлтүүд танд нээгдэх эдгээр бүх шинэ үүд хаалгууд таны сайн сайхны төлөө гэдгийг мэдэх хэрэгтэй. Бүх зүйл таны сайн сайхны төлөө. Тэгээд таны сайн сайхан бол таны хөгжил дэвшил юм. Өөр юу ч биш. Харин өсөлт дэвшил чинь юм. Бусад бүх зүйлс бол бүгд хэрэггүй, өгөөжгүй юм. Амьдралдаа үүнд л хүрэх ёстой гэдгийг ойлгоод ирвэл. Энэ л баярлах зүйл чинь гэдгийг мэдвэл энэ нь сэргэж эхлэнэ. Сахажа йог-т үүнийг харвал энэ нь нийгүүсэл, хайрын хүч юм. Хориглож цээрлэх их зүйлс байхгүй. Өөрөө өөрийгөө хөгжүүлэхийг өөрт нь л орхисон байдаг. Өөрсдийн Амин Сүнс чинь л таныг чиглүүлнэ. Ямар ч хяналт, мөрдөлт байдаггүй. Харин үүнийг танд, өөрт чинь орхисон байдаг, өөрөө өөрийгөө ойлгох, өөрөө өөртөө харж мэдэн авах мөн засах аргыг олгодог. Хэмжих нэг шалгуур нь бол, "сахаж яогт би юу хийсэн бэ" гэсэн зүйл байх ёстой. Эхийн төлөө би юу хийсэн бэ? Энэ хоёр зүйл бол маш чухал. Ойлговол. Сахажа йоганд хийж чадах ямар ч жижиг зүйл байлаа, маш чухал, яагаад гэвэл, та жаахан ч гэсэн ухаантай бол ойлгоно, хүний хийх боломжтой хамгаас дээд зүйл бол Бурханы ажлыг хийх. Энэ бол, одоогийн байдлаар хүмүүст олдоод байгаа хамгаас чухал зүйл юм. Хүмүүсийн хийж болох хамгаас дээд үйл ажиллагаа юм. Хүнд барагтаа олдоод байдаггүй хамгаас дээд боломж, завшаан юм. Тэгээд энэ ямар том завшаан билээ. Магадгүй та бүхэн, "Эх минь бид дундаж хүмүүс, мундаг биш, хэрэггүй хүмүүс" гэх байх. – Гэхдээ, та бүхэн сонгогдсон. Та бүхэн сонгогдсон хүмүүс. Тиймээс ямар нэгэн шалтгаан байж л таарна. Магадгүй, та бүхэн энэ ажлыг боловсруулах тэр хэсгийг өөр дотроо олж хараагүй байх. Энэ бол Бурхны агуу ажил юм. Тиймээс та бүхэн байршилаа олоод, би яагаад сонгогдсон гэдгийг олж мэд. Сахажа йогт би юу хийж болох вэ, ол. Сахажа йогт би юуг боловсруулж чадах уу? Энэ танд тогтмол үргэлжилсэн сануулга болж байх ёстой. Би сахажа йогийн ажилд сонгогдсон Сахажа йогийн бүрэн боломжийг эдэлмээр байна. Жишээ нь, хэн нэгэн мөнгөгүй бол сахажа йога нь түүнд мөнгө олгох ёстой гэж боддог, ажилтай болгох ёстой, ийм, тийм юм өгөх ёстой, хүүхэдтэй болгох ёстой, эрүүл байлгах ёстой, энэ бүх хүлээлтүүд байдаг Хүлээлтүүд байдаг, яахав. Гэхдээ, "би өөрөө сахажа йоганд юу хийсэн бэ?" Энэ бол дотроо харах бас нэг зүйл юм. Энэ зүйлийг ойлгох нь маш чухал, бид сахажа йоганд ямар нэгэн зүйл хийх ёстой юм. Энэ бол мөнгө биш. Энэ бол ажил биш. Энэ бол бодол биш. Энэ бол ямар нэгэн тусламж дэмжлэгийн зүйл биш. Хамгаас чухал зүйлийн нэг бол хэдэн хүмүүсийн зулайг нээж, оюуныг нь сэргээсэн бэ? Энэ чухал. Та бүхэн тоолох хэрэгтэй. Хэдэн хүмүүст Оюуны хүчийг нь сэргээж чадсан байна? Хэдэн хүнд сахажа йогийн талаар хэлсэн байна? Яахав та зарим хүмүүсийн Оюуныг сэргээж өгч байна гэж бодож болно. Тэд ирээд алга болж байна. Хамаагүй. Эцэст нь тэд ирэх л болно. Өнөөдөр, та зарим хүн дээр үзлээ, тэд алга болно. Маргааш нь дахиад үзээд, цуцалтгүйгээр ажиллах хэрэгтэй. Би Англи-д маш их ажилласан, та мэднэ. Англи-д ирэх нь хүртэл миний хувьд маш их шийдвэр шаардсан ажил байсан. Энд, би ирэх шаардлагатай байсан юм. (Дэлхийн) зүрхний хүрдийг сайн болгох хэрэгтэй байсан учир. Гэтэл зүрх нь идэвхгүй лазан байна, та нар мэдэж байгаа. Идэвхгүй зүрх нь төрөл бүрийн асуудалд ордог. Харин эдгээр бүх жилүүдэд боловсруулж ажиллаад, Жил бүр, би бүх л боломжит цаг заваа, сахажа йогчидод, тэдний асуудалд, сахажа йогт зориулсаар ирсэн. Тэдний жижиг асуудал бүрт, тэдэнд хэрэгтэй ямар ч тусалцаа, бүх л төрлийн зүйлийг би боловсруулахыг хичээсэн. Шууд болон шууд бусаар та бүхэн бүгд ерөөлөөс хүртсэн. Гэвч, өнөөдөр йогчид болсон та бүхэн ямар байна? Та бүхэн гэгээрсэн. Та бүхэн надаа байгаа маш сонирхолтой зургийг үзээрэй. Тэр зурган дээр та бүхэн бүгд гэрчилгээтэй гэгээнтнүүд болсон нь харагдаж байгаа. Тэр зургийг үзсэн үү? Үгүй юу? Үзсэн нь дээр. Үзүүлье. Зураг миний хайрцаганд байгаа. Та бүхэн бүгд гэрчилгээтэй гэгээнтнүүд. Бурхнаас гэрчилгээтэй болсон хүмүүс. Ямар нэгэн кардинал, лам нараар цоллуулсан хүмүүс биш. Тиймээс тэр бүх, ламаар цоллуулсан нэг хуурамч гэгээнтэн ямар их зүйл болдог билээ. Хуурамчаар гэгээнтэнд гэрчилгэсэн ч, маш том зүйлд тооцогддог. Харин Агуу Бурхнаар цоллуулсан та бүхэн яаж байна? Та бүхэн өөрийн ажилдаа завгүй л хэвээрээ, өөрсдийн жижиг, жижиг зүйлдээ автаад л завгүй, өөрсдийн жижиг амьдрал, жижиг гэр бүлдээ автаад маш завгүй. Гэгээнтэн хүний хувьд, санскрит хэлээр: Өгөөмөөр хүний хувьд, гэгээнтэн хүний хувьд бүх л хорвоо ертөнц өөрийнх нь гэр бүл байдаг. Та өдий хүртэл зөвхөн өөрийн гэр бүлдээ л зовсоор байна уу? Тэгвэл та өөрийн гэгээрлийг ухаараагүй л байна. Гэгээнтэн хүн зөвхөн өөрийн хань, өөрийн хүүхэд, өөрийн байшиндаа л зовоод байдаггүй. Гэгээнтэн хүн бүхий л хорвоо ертөнцөд санаа тавидаг. Одоо, та бүхэн, сахажа йогчидын хувьд маш хүчтэй хүмүүс болсон. Та бүхэн маш хүчтэй. Дэлхий даяар хүмүүс асуудалтай байна, та бүхэн сайн мэдэж байгаа. Та бүхэн заавал агуу ухаантай, бодлоготой улс төрчид зэрэг тийм хүмүүс болох хэрэггүй. Гэхдээ та бүхэн энэ дэлхийг зовоож буй асуудлуудыг харж байх хэрэгтэй. Тэгэх хэрэгтэй. Зүгээр өөрийн ертөнцдөө амьдраад, одоо би гэгээрсэн, би баяр баясалын түвшинд ирсэн гээд байж болохгүй. Зүгээр "нирананда"-д байгаад байж болохгүй, энэ амьдралд амьдрах ёстой гэдгийг мэд. Мөн энэ амьдралын бүх асуудлуудыг мэдэх ёстой. Мөн тэдний талаар бодох хэрэгтэй. Зөвхөн өөрийн асуудлыг биш, "Эх минь би яаж үүнийг, яаж тэрнийг хийх чадвартай болох вэ?" гэх биш ээ. Харин, бүх ертөнцөд

санаа тавих хэрэгтэй. Дэлхийд юу болж байна, ямар асуудалтай байна, санаа тавьж байх хэрэгтэй. Энэ та бүхний хариуцлага. Үүнээс гадна мөн залбирч байх хэрэгтэй. Өөрийн залбиралдаа, "Эх минь, энэ асуудлыг шийдээч" гэж гуйж байх хэрэгтэй. Ганцаараа, Нийтээрээ. Та бүхэн өөрийн анхаарлаа хувийн жижиг амьдралаас илүү агуу хэмжигдэхүүнд авчирах хэрэгтэй. Тэгвэл та гэгээнтэн юм. Та бүхэн Бурхны тусламжийг хүсч гуйх нь та бүхний үүрэг гэдгийг мэдэх хэрэгтэй. Эдгээр асуудал нь шийдэгдээсэй гэж. Энэ бол та бүхний хийх ёстой ажил чинь юм. Үүний тулд л та бүхэн сонгогдсон юм. Та бүхний хүсэлт, залбирлаар эдгээр бүх зүйлс шийдэгдэнэ. Яагаад гэвэл би ямар ч хүсэлгүйг та бүхэн мэднэ. Та бүхэн хүсэх ёстой. Та бүхэн юу л хүснэ, тэр чинь зүйлсийг шийднэ. Эхийн хамгаалт, халамж, нийгүүсэл нь таны талд байгаа. Харин та бүхэн энэ ертөнцийг харан халамжилж, санаа тавих ёстой. Хязгаарлагдмал хүрээнд, хязгаарлагдмал аргаар амьдрах ёсгүй. Жишээ нь, одоо энд Англичууд, Английн асуудлууд биднийх л гэж боддог. Үгүй ээ. Та бүхний асуудлууд Сахажа йога байгаа бүхий л газарт түгж байгаа. Тиймээс та бүхэн бусад бүх нийтийн төлөө санаа тавих хэрэгтэй. Жишээ нь, Австралид нэг асуудал байна. Тэнд нэг маш асуудалтай хүн байна. Та бүхэн үүнийг харах хэрэгтэй. Тэр хүнийг шахайдаад, энергээр засч туслах хэрэгтэй. Удирдагч чинь хэнийг засах гэдгийг хэлэх хэрэгтэй. Тэгээд боловсруул. Австралид ч байлаа, АНУ-д ч байлаа, Энэтхэгт ч байлаа. Хаана ч байсан. Сахажа йоганд ямар нэг асуудал гарч байвал, бүгд тийш анхаарлаа хандуулан энергиер боловсруулах хэрэгтэй. Тэгээд мөн ерөнхий асуудал байдаг. Жишээ нь АНУ, маш тэнэг болж байна, өөр юу гэж хэлмээр юм, маш ухаангүй болж байна. Тиймээс, та бүхэн бүгд анхаарлаа АНУ-руу хандуулах хэрэгтэй. Та бүхэн анхаарлаа гадагш тэлэх хэрэгтэй. Зөвхөн дотогшоо, өөрийнхөө төлөө, өөрийн гэр бүл, байшин, өөрийн хүүхдүүдийн төлөө санаа зовох биш. Анхаарлаа гадагш тэлж эхлэнгүүт л өөрийн гэрийн чинь асуудлууд шууд шийдэгдэнэ. Жижигхэн цагирагандаа тэр нь шийдэгдчихдэг. Та бүхэн анхаарлаа гадагш хандуулах хэрэгтэй. Өдгөө хүмүүс ТВ зурагттай. Эхлээд бид зурагт бүү үз гэдэг байсан. Яагаад гэвэл тэд зурагт үзэнгүүтээ л (муу энергийн) халдвар авчихдаг байсан. Харин одоо бол амьдралд болж буй чухал зүйлсийг та бүхэн өөрсдөө үзэн анхааралдаа ав. Дэлхийд ямар асуудал байна, өөрсдөө анхаарлаа хааш нь хандуулах нь зүйтэйг хар. Та бүхэн өөрсдийн үнэ цэнэ, хүчээ мэдэх хэрэгтэй. Та бүхэн нэг маш жижиг хүрээнд хамрагдсан, жижиг жижиг зүйлсд бүхэлдээ орооцолдсон хүмүүс биш. Та бүхний онцлог чанар бол бүхий л огторгуй ертөнцийн асуудалд санаа тавих хүмүүс. Та бүхэн гайхна. Бүх байгаа асуудлууд, бүх зүйлсүүд шийдэгдэж болдогийг харна. Маш их хамтын хүчээр. Тэгээд энэ байгаа түвшиндээ, та бүхэн өөрсдийгөө харж болно. Бүх сахажа йогчид толгой дээрээ долгионтой байна. Та бүхэн энэ зургийг бүгдээрээ үзэх үү? Та бүхэн үзээрэй. Бүгд (Энэтхэгийн) Ганапатипуле-д сууж байгаа үед дарсан зураг. Тиймээс өөрийн энергийн долгионоо тэлж түгээ. Анхаарлаа тэл. Тэгээд та бүхэн гайхна, бусад бүх утгагүй асуудлууд чинь алга болно. Зургийг хар. Эхлээд хүүхдүүдэд үзүүл. Зүгээр хар. Та бүхэн бүгд толгойн дээрээ Бурхны долгионтой байна. Уйлж байгаа хүүхдийг аваарай. Юу болоо вэ? Охин ядарчихсан гэж бодно. За. Сууцгаа. Сууцгаагаарай. Наашаа ир, суу. Эргээд хар. Суньяа охин, наашаа хараад суугаарай. Наашаа харцгаана уу. Байна уу (хүүхдүүдээ). Бүгдээрээ сууцгаа. Ухаалаг бай. Тэдэнд том болох боломжийг нь олго. Би тэдний том болохыг нь л хүлээж байна. Тэгэхлээр, бид өөрсөддөө хандах хандлагтаа бид өөрсдийн агуу байдал, өөрсдийн түвшин, байр сууриа мэдэж, гэгээнтэн гэдгээ ухамсарлан бид хамгаас өндөр зэрэгт ирсэн гэдгийг мэдэх хэрэгтэй. Тэгээд, бид гэрэл болсон мөн бусдад гэрэл өгөх ёстой гэдгийг мэдэх хэрэгтэй. Хэрвээ библийг авбал, Христ маш чухал зүйл хэлсэн. "Гэрлийг ширээн доор бүү тавь" гэсэн байдаг. Тийм зүйл юм. Та бүхэн тэр Гэрлийг эндэрт залах ёстой. Тийм зүйл байгаа юм. Та бүхэн өөрсдийн Гэрлээ орд шилтгээнд залах хэрэгтэй. Бусдад гэрэл өгөхийн тулд хамгаас өндөрт залах хэрэгтэй. Энэ нь аль аль талд үйлддэг. Хэрвээ өөрийгөө хэн гэдгийг ойлгоод, юуг ухамсарлах ёстойг мэдээд ирвэл. Таны нөхцөл байдал юу билээ, ямар хүчтэй болсон байна, Сахажа йогт ирээд юунд хүрсэн бнэ? Сахажа йогийн үйл хэрэгт хэр гүнзгий хандаж байна? Мөн Сахажа йогт юу өгөх ёстой вэ? Сахажа йога таныг хэрхэн ийм мундаг, чадварлаг, ийм сайн, сайхан болгосон байна? Та хангалттай шудрага байна уу? Та биеэ зөв авч явж байна уу? Бүх шаардлагатай, зөв зүйтэй зүйлсийг хийж байна уу, та? Яагаад гэвэл, зөвхөн та бүхэн л үүнийг хийж чадна. Та бүхэн маш их, маш их онцгой энергитэй, Амин сүнсний маш онцгой холбоотой (Бурхны) хүмүүс. Хэрвээ та бүхэн бусад бүх энгийн утгагүй хүмүүстэй адилхан байгаад, өөрсдийгөө гэр бүл, өөрсдийн хүүхэд, өөрсдийн утга учиргүй өмнөх амьдралууддаа хязгаарлаад, чөдөрлөөд байвал та унах болно. Өөртөө ч олдогдохгүй, мөн бусдад ч олдогдохооргүй унана. Асуудлууд бол та бүхний мэдэхээс ч илүү байна. Энэ бол, Дарь Эх биднийг йогчид болгосон гэдгийг ойлгох ойлголтолтонд та бүхэн хүрэх хэрэгтэй. Бид гэгээнтнүүд. Бид дэлхийн хүмүүст зөв замыг нь харуулах ёстой. Дарь Эх биднийг Гэрэлтэй гэсэн, бид хүмүүст аль замаар явах, хэрхэн цааш, яаж урагшилах замыг тавих ёстой. Гэтэл, оронд нь өөрсдөө асуудалтай болчихсон байж байдаг. Маш жижиг цөөрөм мэт ертөнцдөө дороо эргээд, эргүүлэгтээ л байгаад байдаг. Яаж тийм байж болдог юм? Би та бүхэнд их хэлсэн. Эдгээр хуурамч багш нарыг хараач. Тэд ямар ч бурхны долгионгүй, Кундалини, Сахажа йог-н талаар юу ч мэддэггүй, Гэхдээ тэд ямар их юм хийж байна. Харин бид юу хийж байна? Бид өөрсөдтэйгээ зүдэрсэн хэвээр л... өөрсдийн

асуудал, өөрсдийн бодол, төсөөлөл, өөрсдийн жижиг сэтгэл, тахиан зүрхэтэйгээсээ болж зүдэрсээр л байна. Энэ бол та бүхэнд зориулсан, танд ойлгуулахын тулд юм. Энэ бол та бүхэн өөрсдөө өөрсдийнхөө төлөө шийдвэрээ гаргах зүйл юм. Энэ бол, таны өөрсдийн хүсэл, өөрсдийн агуу байдал, уудам сэтгэлд чинь илрэх ёстой зүйл юм. Өөрөө өөртөө, өөрийгөө ямар чадвартай, юу хийх чадвартайг үзэх зүйл юм. "Эх минь, энэ хэт их том зүйл юм, би юу ч хийж чадахгүй" гэж хэлэх маш амархан. Эсвэл зарим нэг нь "Эх минь, би гэр бүлтэй, завгүй" гэнэ. Эсвэл зарим нь би хүүхдүүдтэйгээ завгүй байгаад байна. Та бүхэн үүний төлөө Сахажа йогт ирсэн юм уу? Би та бүхний хүчийг үүний улмаас сэргээсэн юм уу? Эдгээр бүх ерөөлүүд үүний улмаас буух уу? Тиймээс та бүхэн тогтворжиж гүнзгийрэх нь маш чухал. Үүнийг маш тодорхой харах боломжтой. Тийм учраас бид шинэ хүмүүсийн хичээлийг хийх боломжгүй байгаа юм. Яагаад гэвэл бид үнэхээр гүнзгийрч тогтворжих хэрэгтэй учир. Англид. Би Англид маш олон жил амьдарсан боловч хүмүүс намайг байдаг л зүйл мэт авч байна. Би энд байгаад, энд амьдардаг учир, хүмүүс намайг нисэх буудалд гаргаж өгөөд л бүх юм болоо, гэж боддог. Хийх ёстой бүх үүргээ гүйцэтгэлээ гэж боддог. Бид нисэх буудалд Эхийг харлаа одоо боллоо, гүйцээ, гэж боддог. Намайг харах ямар хэрэгтэй юм. Би өөрт чинь ямар нэг юм өгөв үү? Гэрэл чинь тэлж байна уу? Хэдэн хүний Оюуныг та сэргээсэн байна? Зүгээр хар, хэдэн хүн өөрөөс чинь Сахажа йогийг сурсан байна. Таны амьдралаас, ухаанаас чинь, бие авч яваа байдлаас чинь? Энэ бол арга нь юм. Шалгуур нь. Зүгээр, би Эх-д хичээл заахаар явахад нь мөнгө өгсөн нь биш. Энэ бол хангалтгүй юм. Миний насанд, Миний насны Энэтхэг эмэгтэйг харвал хэдийнээ таягтай явдаг, шатаар ч гарж чаддаггүй. Энэтхэг эмэгтэйчүүд чаддаггүй, биенд нь хураагдсан хэт халууны улмаас. Харин би маш их аялдаг, намайг хэр их аялж түгээдгийг та бүхэн мэднэ. Би бас гэр бүлтэй. Тэд яахав? Би тэднийг орхиод, хамт байхаас хомсолж байна. Нөхрөө хомсолж байна. Тэд бүгд надгүйгээр байдаг. Би өдөр бүр, өдөр бүр аялаж байна, та бүхэн сайн мэднэ. Би маш их хүнд ажилладаг. Заримдаа би шөнийн 02 цагт, заримдаа 03 цагт унтдаг. Энэ удаа, надтай Харш хамт явсан. Тэр бүүр ядраад уначихсан. Тэгээд би энэ яг холын замын уралдаан шиг гэж хэлсэн. Би Австралид байвал Австраличууд надтай ажилладаг. Тэгээд Австрид байвал Австричууд хамтдаа ажилладаг. Тэгээд тэд тэндээ үлдээд сайхан байдаг. Би Англид байвал, Англи арай илүү засрагдсан газар. Тэд бүгд суугаад жаргаж байдаг. Би ямар байна? Би холын замын гүйлтэнд л байгаа мэт. Үүнтэй адил та бүхэн үүнийг мэдрэх хэрэгтэй. Эцсийн эцэст би юу хожив. Үүнээс би юу олов? Би нэг зүйлийг олсон. Би өөрийн хүүхдүүдийг буцаагаад эрүүл болгосон. Би тэднийг Бурхны оршихуйд оруулсан. Та бүхэн адилхан хийх хэрэгтэй. Бусад хүмүүсийг Бурхны орон руу авчирах хэрэгтэй. Гэтэл, та бүхэн өөрсдийн төөрөлдөлдөө л байгаад байх юм бол өдөр бүр доошоо, доошоо, доошоо унасаар байна. Би хашгирч, дуудаж, юу ч хэлнэ, та бүхний толгойнд хүрэхгүй. Толгойнд чинь буухгүй. Өөрсдийн байгаа газартаа л уягдана, хэрвээ харахыг хүсэхгүй байх юм бол. Үүнд хэлэхэд, та бүхэнд нэг давуу талтай. Ялангуяа Англид. Та бүхэн маш ухаалаг хүмүүс. Та бүхэнд бодох ухаан бий. Гарцаагүй Та бүхэн Америкчууд шиг тэнэг хүмүүс биш. Та бүхэн тархиндаа ухаантай. Гэхдээ тэр ухаан чинь муу санаа болон хувирч. Эрт урд цагт. Тэгээд одоо та бүхэн өөрийн муу санаанаас залхсан. Гэтэл Энэтхэгчүүд та нарын муу санааг сурсан. Тэд үнэхээр зальтай болсон. Гэхдээ та нар муу санаанаас залхсан. Тэгээд одоо маш ядарчихсан, залхчихсан, цуцчихсан, лазан болчихсон байна. Гэхдээ өөрсдийн тархины ухаанаар та бүхэн ойлгоно. Эх нь маш чухал ажил хийж буйг ойлгоно. Та бүхэн түүхэнд бичигдэх болно. Хэлсэн үг, зүйл болгон чинь, биеэ авч явах байдал бүр чинь, бүх зүйл түүхэнд бичигдэн үлдэнэ. Хэдэн хүүхэдтэй болсон, ямар эхнэртэй байгаа чинь бичигдэхгүй. Харин Сахажа йогт юу хийсэн чинь бичигдэнэ. Үүний санаж ав. Түүхэнд та бүхний юу хийсэн бичигдэнэ. Сахажа йоганд юунд хүрсэн чинь бичигдэх болно. Гаднаа гайхуулах зүйл биш, зүгээр үзүүлэн биш мундаг ярих зүйл биш. Ямар ч тийм зүйл биш. Энэ бол үнэндээ, үнэхээр та үнэмлэхгүй (оюуны түвшинд) юунд хүрсэн байна тэр чинь бичигдэн үлдэнэ. Хуурамч дүр үзүүлэхийг Бурхан мэднэ, мөн хөөрүү хээнцэрлийг мэднэ. Бурхан та бүхний хаана буйг мэднэ, мөн яах гэж буйг чинь мэднэ. Та Бурхныг хуурч чадахгүй. Нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Бурхныг мэхлэнэ гэж бодож байвал өөрийгөө л мэхлэж буйгаа мэд. Өөрийн амин сүнс, өөрийн ухаарал, гэгээрэл, өөрийн хөгжил дэвшилээр тоглоно гэсэн үг. Тиймээс бид болгоомжтой байх хэрэгтэй. Эхийн хувьд би сануулахад та бүхэн өөрсдийгөө маш анхааралтай дүгнэхийг хичээ. Сахажа йогт би юу хийсэн бэ? Бусад хүмүүсийн дэвшилд би юу хийв? Бусад сахажа йогчидод би яаж хандаж байна? Хэр их амар амгалан, хайр, нийгүүслийг бид бусдад өгөв? Хэр их ойлголт, тэсвэр хүлээцтэй бусад хүмүүсд хандав? Зарим нэг хүн жаахан мөнгөтэй болонгуутаа маш их хөөрсөн бардам болж, маш их түрэмгий, маш бүдүүлэг болдог. Үүнд би итгэж чадахгүй юм. Яаж та мөнгөнөөс болж тийм зантай болж байна? Та бүхэн жирийн хүмүүс биш. Та бүхэн хөлөө Ганга мөрний усаар угаалгасан гэгээнтнүүд. Өөрсдийн сүр жавхлан, өөрсдийн хүч чадвар, өөрсдийн байр суурийг ойлгохыг хичээ. Гэгээрсэн хүмүүсийн хувьд сахажа йогчид та бүхэн бусдаас дээгүүр юм. Яагаад гэвэл та бүхэн Оюуныг сэргээж чадна. Яагаад гэвэл та бүхэн Кундалини-н талаар бүх зүйлийг мэднэ, Оюуны ухамсрын талаар бүх зүйлийг мэднэ. Хэр их хүн энэ талаар мэддэг байв? Эс тэгвээс эдгээр бүх мэдлэгийг бүлэг тэнэгүүдэд өгчиж гэж бодогдоор. Үнэ цэнийг мэддэггүй хүмүүст... Христос хэлж байсан, шүр сувдаа гахайнд бүү хая,

гэж байсан. Би тийм алдаа хийсэн гэж бодохгүй байна. Гахайнуудад сувд шүр цацаж өгсөн гэж бодохгүй байна. Би тэгээгүй байлгүйдээ. Гэхдээ, үүнийг та бүхэн өөрсдөө харж, аль зэрэгт нь байгаагаа өөрсдөө шийдэх хэрэг. Бид маш адарматай цаг үеийг давж гарах хэрэгтэй байгаа нь маш тодорхой. Үүнтэй бид тэмцэлдэн ялан гарах нь маш чухал юм. Энэ бол өмнө байсан аль ч дайнаас илүү ... Энэ бол өмнө байсан аливаа зүдгүүрээс бүүр илүү. Энэ, маш аймшигтай ертөнц үүссэнийг бид өөрчлөх хэрэгтэй байна. Энэ бол агуу их үүрэг ажил юм. Үүний тулд та бүхэн туйлын чин сэтгэлээсээ, дотроосоо ажиллах ёстой. Тэгээд, би бат итгэж байна, цаг нь ирэхээр энэ ертөнцийн түүхэнд сахажа йогчидын нэрс алтан үсгээр бичигдсэн байх болно. Энэ нь болно гэдэгт би итгэлтэй байна. Болох ёстой гэдэгт бат итгэж байна. Үүнд та бүхэн бүгд үүнд хүрэх хэрэгтэй. Хамтдаа, нэг сэтгэлээр, нэг зүрхээр... Би юуг тэвчиж золиослох вэ? Би юу хийх ёстой вэ? Яаж туслах вэ? Миний нэмэр хаана, юунд байна? Тэдгээр өдрүүдийг би өөрийн амьдрах хугацаандаа үзэх юмсан гэж хүснэ. Тиймээс өнөөдөр бол бид өөрсөд рүүгээ харж дүгнэх өдөр юм. Бид бясалгалдаа орох хэрэгтэй учир, нүдээ анина уу.

Өнөөдөр бид дотогшоогоо өөрсдийгөө харах хэрэгтэй өдөр. Бясалгалдаа бүгдээрээ орцгооё. Нүдээ аницгаана уу. Бүгдээрээ нүдээ ань. Одоо бүгдээрээ шинэ хүмүүст зориулж хийдэг (том зааланд хийдэг шиг) эхний бясалгалыг хийнэ. Эхлээд зүрхэн дээрээ гараа тавья. Биеийн зүүн хэсэгт ажиллана. Зүүн алгаа над руу хандуул. За. Юун түрүүнд гараа зүрхэн дээрээ тавь. Зүрхэнд Шива оршдог. Амин Сүнс нь юм. Тиймээс, өөрийн Амин Сүнсэндээ талархах хэрэгтэй. Анхаарлыг чинь гэгээрүүлсэнд таларх. Та бүхэн гэгээрсэн учир, зүрхэнд чинь буусан гэрэл бүх дэлхийг гэгээрүүлэх ёстой. Тийм учир, зүрхэндээ залбир... Энэ зүрхэнд минь буусан миний Тэнгэр/Бурхны хайрын гэрэл бүх дэлхийд түгэх болтугай. Чин сэтгэлээсээ. Тэнгэр/Бурхантай холбоотойгоо ухаар, тиймээс хүссэн бүхэн чинь биелнэ. өөртөө бүрэн итгэлтэйгээр чин сэтгэлээсээ хий. Баруун гараа гэдэсний дээд хэсэгт, зүүн талд нь тавь гэдэсний дээд хэсэгт, зүүн талд нь тавь. Энд Энд таны "Дхарма" байрлах төв юм. Энд, та бүхэн "Вишва Нирмала Дхарма" (Даяар ариун оюун) бүх дэлхийд тархах болтугай гэж залбир. Хүмүүс бидний ёс зүйтэй амьдралын гэрлийг харах болтугай. Бидний зөв зүйтэй амьдралыг хараад хүмүүс "Вишва Нирмала Дхарма" (Даяар ариун оюун)-г хүлээх болтугай. Улмаар, тэд гэгээрч, амьдрал нь буянтай, гэгээлэг болох болтугай. Дээшээ өгсөхийг хүсдэг болох болтугай. Одоо, гэдэсний доор зүүн хэсэгт баруун гараа (цавь руу нь) тавьж чанга дарна Энд цэвэр мэдлэг оршидог, Энд та бүхэн Сахажа йогчидын хувьд, Бидний Эх бидэнд, Тэнгэр/Бурхан хэрхэн ажилладаг талаар бүрэн ойлголт өгсөн. Бидний дааж, ойлгох хэрээр бидэнд бүх тарни, бүх цэвэр мэдлэгийг өгсөн, Намайг энэ талаар бүрэн мэдлэгтэй болгооч. Бүгдээрээ (хүс). Би харсан, нөхөр нь удирдагч байхад эхнэр нь сахажа йогийн талаар юу ч мэддэггүй. Эмэгтэй нь мэддэг байхад, нөхөр нь юу ч мэддэггүй байх жишээтэй. Намайг мэргэжлийн түвшинд, гарамгай мэдлэгтэй болгож өгөөч. Энэ мэдлэгт. Улмаар, би хүмүүст Оюуныг нь сэргээх чадвартай, Бурхан/Тэнгэрийн хууль гэж юу гэдгийг ойлгуулах чадвартай болох болтугай, Кундалини гэж юу юм, чакра хүрднүүдийн талаар ойлгуулах чадвартай болох болтугай Анхаарал минь ердийн амьдралын зүйлээс илүү сахажа йоганд байх болтугай Одоо, баруун гараа гэдэсний дээд хэсэгт тавь. Нүдээ ань. Энд, зүүн талд нь дар. Энд: Эх надаа Сүнс хайрласан. Улмаар миний өөрийн багш бол Ариун Сүнс. Би өөрөө өөрийн багш. Огоорол задгайрал үгүй, эрхэм чанартай болоосой. Айл араншиндаа өгөөмөр болох болтугай. Бусад сахажа йогчдод хайртай, нийгүүсэнгүй байх болтугай. Гайхуулах биш, харин Бурхны хайрын, Бурхны үйлдлийн талаар гүнзгий мэдлэгтэй болгож өгөөч. Хүмүүс ирэхэд нь сахажа йогийн талаар хэлэх чадвартай болгож өгөөч. Энэ агуу мэдлэгийг, даруухнаар, хайраар дамжуулах чадвартай болоосой. Одоо баруун гараа зүрхэн дээрээ авчиръя Энд, бид Бурханд талархах хэрэгтэй. Далай их баярыг мэдэрсэнд талархъя. Далай их өршөөлийг мэдрүүлсэнд талархъя. Бидний Эх-д байдаг өршөөх чадвар нь агуу гэдгийг бид харсан Миний зүрх тэлэн уужирч, бүх ертөнцийг багтаах болтугай Миний энэ хайр Бурхны нэрийг дуулан дуу гаргаж байх болтугай Зүрх нь хором бүрт Бурхны хайрын үзэсгэлэн гоог харуулж байх ёстой. Одоо баруун гараа Вишүүдхи-н дээрээ авчир Зүүн Вишүүдхи-н дээр, мөр хүзүүний хооронд, булан дээр Би гэм буруугийн хуурмагт автахгүй. Энэ нь хуурамч гэдгийг би мэднэ. Би өөрийн хуурмагаас зугтахгүй, харин нүүрлэн тулж арилгах болно. Бусдаас би бурууг хайхгүй харин өөрийн сахажа йогийн мэдлэгээрээ, бусдын хуурмагийг арилгахыг болгооно уу. Бидэнд маш олон арга бий, нууцаар бусдын дутагдлыг бид арилгаж болно. Миний хамт олонч зан чанар агуу болон хувирах болтугай. Улмаар бүх сахажа йогийн үндэстэн миний өөрийн гэр бүл, миний өөрийн хүүхдүүд, миний гэр, миний бүх зүйл болох болтугай. Энэ ухаагдахуун нь надаа бүхэлдээ дотроос минь бүрэн сэргэх болтугай. Би бүхэл бүтний нэг хэсэг, яагаад гэвэл бид бүгд нэг Эхтэй. Миний анхаарал бүх дэлхийг багтааж байх болтугай хүмүүсийн асуудал юу байна, би хэрхэн өөрийн үнэнхүү хүсэл, үнэнхүү хүчээр шийдэх боломжтой байна. Дэлхийн асуудлуудыг зүрхэндээ мэдэрдэг болгооч тэгээд дотроос нь, үндэснээс нь арилгаж бүхнийг нь үндэснээс нь, гарсан шалтгаанаас нь, гарч байгаа үндэснээс нь арилгаж байх болтугай. Эдгээр бүх асуудлын үндсэн зарчим руу нь орж, өөрийн сахажа йогийн, гэгээрлийн хүчээр арилгахыг

хичээх болтугай. Баруун гараа духан дээрээ хөндлөнгөө тавина уу. Энд, юун түрүүнд, Сахажа йогт ирээгүй бүх хүмүүсийг өршөөе гэж хэлэх хэрэгтэй. Гаднах зааг дээр яваад байдаг, ирчээд, алга болдог, үсэрч ороод, үсрээд гардаг бүхнийг... Гэхдээ, юун түрүүнд, хамгаас илүү бүх сахажа йогчидыг өршөөх хэрэгтэй, яагаад гэвэл тэд бүгд надаас илүү. Би тэднээс алдаа хайхыг хичээдэг, гэхдээ би өөрөө хамгийн доор нь, тиймээс би тэднийг өршөөх хэрэгтэй, яагаад гэвэл би өчнөөн их цааш, хол явах хэрэгтэй гэдгээ мэдэх хэрэгтэй би маш доор байгаа, би өөрийгөө өчнөөн сайжруулах хэрэгтэй. Ийм даруу зан бидэнд нээгдэх ёстой. Тиймээс, энд: миний зүрхэнд буй даруу зан минь үнэн утгаараа, хураамчаар биш, засрагдан боловсорч, өршөөх мэдрэмж нь сэргэж, улмаар би бодит байдлыг, Бурханыг, Сахажа йог-г ухаарч, мэхийн ёслох болтугай. Одоо гараа толгойн ар тал, дагзан дээр тавиад, толгойгоо гэдий. Энд та бүхэн: Эх минь, өдий хүртэл таны эсрэг хийсэн буруу зүйлсийг минь өршөөгөөч, толгойнд орж ирч буй аливаа муу зүйлс танд харуулсан бүх өчүүхэн байдлыг таныг зовоон, сорьсон аливаа зүйлийг өршөөгөөч. Та бүхэн өршөөл гуйх хэрэгтэй. Өөрийн ухаандаа намайг хэн гэдгийг мэднэ. Би дахин дахин хэлээд байх шаардлагагүй. Сахасрара-д бол та бүхэн надаа талархах хэрэгтэй. Сахасрара дээр гараа тавиад 7 эргүүл. Надаа 7 удаа таларх. Эх минь, Оюуныг минь сэргээсэнд баярлалаа. Эх минь, бид ямар агуу гэдгийг ойлгуулсанд баярлалаа. Бурхан/Тэнгэрийн бүх ерөөлийг өгсөнд баярлалаа. Биднийг байх байснаас маш дээш нь гаргасанд баярлалаа. Мөн бидний тэтгэн дэмжсэнд баярлалаа, тусалсанд баярлалаа Өөрсдийгөө засан залруулахад тусласанд баярлалаа. Тэгээд эцэст нь, Та энэ дэлхийд ирсэнд баярлалаа, хүн болж төрөөд бид бүхний төлөө маш их ажиллаж буйд баярлалаа. Чанга дараад, (хуйхыг нь) сайн хөдөлгө. Доошоо суу, доошоо суу... Одоо гараа буулга. Толгойнууд чинь маш халуун байна. За одоо, сайхан банддан хийе. Өөрсдийн Эхийн бандданд өөрийн зүүн урсгалыг баруун тал руу нь оруулъя. Нэг. Сайхан хий. Өөрийгөө ямар аура-тай хэн гэдгийг ойлгож хий. Одоо дахиад. 2-дахь удаа Одоо 3-дахь удаа Одоо, 4-дөхь Одоо, 5 дахь удаа Одоо, 6-дахь удаа Одоо, 7 дохь удаа. Кундалини-гаа өргө. Кундалини-гаа өргө. Удаан. Маш удаанаар. Өргө. Эхний үед та бүхэн маш удаан хийх хэрэгтэй. Толгойгоо гэдийгээд, зангид. 1 зангид. 2 дахь удаа. Маш удаан хийгээрэй. Мөн өөрийгөө хэн гэдгээ ухаарч хий. Та нар бол гэгээнтэн. Үүнийг, сайтар хий. Сайтар, гүйцэд хий. Яаралгүй. Толгойн дээрээ авчир. Гэдий. Тэгээд 2 зангид. Нэг, хоёр За, дараачийнхийг нь хийе. Дахиад. 3-дахь удаадаа 3 зангидана. Маш удаанаар хийгээрэй. Маш удаан. Гүйцэд, сайн хийгээрэй. Толгойгоо гэдий. 3 удаа зангидаарай. За одоо өөрсдийн долгионоо хар. (хүүхдүүдэд) Долгионоо хараарай. Ингээд. Бүх хүүхдүүд долгионоо үзээрэй. Гараа ингээд бариарай. За зөв, болсон уу? Сайн байна. Гайхалтай, сайхан. Би та нараас долгион мэдэрч байна. Бурхан ерөөх болтугай. Баярлалаа.

2000-0916, Shri Ganesha Puja (part)

View [online](#).

Shri Ganesha Puja. Cabella Ligure (Italy), 16 September 2000.

Гэмгүй чанарын утга агуулгыг ойлгож байгаа эсэхийг чинь сонирхоно. Гэмгүй, цайлган чанар бол дотоод чанар юм. үүнийг хүчээр байлгах боломжгүй үүнийг сургах боломжгүй. Энэ бол зөвхөн дотроос ундрах чанар юм хүн дотор байдаг.. Хүн, Шри Ганеша-г сүсэглэх шавь нь болвол, хүн өөрөө гэмгүй ариун болдог. Магадгүй та бүхэн, гэнэн хүмүүс зальтай хүмүүсд дээрэлхүүлдэг, түрэмгийлүүлдэг гэж боддог байх. Гэвч гэмгүй чанар бол маш агуу зүйл Хэзээ ч юунд ч дарагдаж устадаггүй. Энэ нь Амин сүнсний чанар юм. Гэмгүй цайлган чанар нь Амин сүнсний чанар юм. Тэгээд энэ Амин Сүнс нь та бүхэнд сэргэвэл, та бүхэн гэмгүй ариун чанартай болдог. Үүний улмаар, та бүхий л муу, бүхий л буруу сүнсний хөгжил дэвшилд, оюунд чинь хөнөөлтэй зүйлсийг давна. Тэгэхлээр, гэмгүй байх гэдэг бол боломжгүй юм. Юу гэвэл, та бүхэн ДОТРООСОО гэмгүй байх ёстой юм. Энэ зүйл нь сахажа йоганд ирж, ОЮУНЫг УХАМСАРЛАДАГ болсны дараа болно. Тэгээд, таны тэмцэх хүч нь... Эдгээр бүх буруу, сөрөг мэдрэмжийн эсрэг - тэмцэх хүч чинь - туйлын ихээр дэмжигдэн, хамгаалагдаж байдаг. Шри Ганешийн Эх нь тэтгэж байдаг. Өдгөө, ариун гэмгүй чанарын талаар хүмүүст ярих нь хэцүү болж. Гэхдээ, та Христ-ын амьдралыг мэднэ. Тэр гэнэн ариуны биелэл байсан. Тэр ямар хүмүүстэй харьцаж байгаагаа мэддэггүй байсан. Бүгдийг нь гэмгүй гэж бодож байсан. Тиймээс тэдэнд хандан ярихдаа, (үйлдэл байдалдаа) башир хүмүүс хэзээ ч тэгж хандахгүй байдлаар ярьдаг байсан. Учир нь башир хүмүүс л бусдын баширыг ойлгож мэддэг. Тэгээд Христ, хүмүүсд ойлгогдоогүй (нарийн) зүйлсийг хэлж байсан Гэхдээ хэлсэн зүйл болгон нь гэмгүй чанарын "долгион" агуулж байсан. Тэр "долгион" нь эдгээр хүмүүсийг эрүүл ухаанд нь оруулж түүнтэй харьцах харилцааг ухааруулдаг байсан. Гэхдээ магадгүй, цаг нь болоогүй байсан болоод ч тэр үү тэр хүмүүсд гэгээрэл ухаарал нь боловсроогүй. Энд Ганеша-гийн гэмгүй ариун чанар нь ялагдаж бүтэлгүйтсэн зүйл биш. Харин эсрэгээр, эргэн тойрондоо үлэмжийн гэгээн сайхан орчныг бүрэлдүүлдсэн. Та бүхэн гэрлэх болсонд би баяртай байна. Хүн яагаад гэрлэх хэрэгтэй гэж? Өдгөө, хүмүүс гэрлэлгүйгээр ч хүртэл хамтдаа амьдарч байна Гэхдээ, гэрлэнэ гэдэг бол хоорондын амьдралыг адислуулна гэсэн үг юм бие махбодь, сэтгэл, санаагаар нэгдэн уусах ерөөлөөр, адислуулах Хэрвээ хүн адислал хүртэлгүй хүнтэй ханилан амьдарч байвал энэ нь төгс төгөлдөр бус, дутуу. Гарсан хүүхдүүд нь зүгээргүй, сайн биш байдаг Тиймээс гэрлэж хуримлах нь маш чухал, шаардлагатай юм. Та бүхэн мэднэ, Христ хурим найранд их очиж байсан Яагаад гэрлэлтэнд тийм их чухал анхаарал хандуулж байсан бэ? Яагаад гэвэл энэ нь хоёр хүний хоорондын холбоог гэгээрүүлж ерөөдөг Бүх зүйл байж болно. Гэхдээ эхнэр нөхөрийн хоорондын холбоо адислагдах ёстой. Эс тэгвээс гарсан хүүхэд, удам нь юу ч болж хувирах боломжтой. Хүүхдүүд нь дээрэмчин, луйварчин, овжин, башир, худалч маш их хэрцгий авиртай удам төрдөг.. Хэрвээ гэрлэлт нь адислагдаж, ариун нүгэлгүй холбоон дээр эс тогтвоос. Тийм учир Христос гэрлэлтийг адислан ивээх гэж очдог байсан. Гэхдээ түүнийг уух дарс архи үүсгэсэн гэдэг нь огт буруу юм. Тэрээр энгийн усыг усан үзэмний амттай болгож хувиргасан. Еврей хэлэнд усан үзэмийг мөн архи гэдэг, адил нэртэй Нэртэй биш. Гэхдээ вино гэдэг үг нь архи мөн адил усан үзэм гэсэн утгатай Гэхдээ ийм зүйл боломжгүй. Учир нь архийг шууд гаргах боломжгүй. Спирт гаргахад хугацаа шаарддаг. Архи дарсыг исэлдүүлж, муудуулдаг. Тэгж байж л спирт үүсдэг. Харин Христ энгийн усыг сахажа маягаар байгалиар нь амттай болгосон юу гэж хор агуулдаг спирт/дарс байх билээ? Маш олон хүмүүс, ялангуяа Христийн шашны хүмүүс Христ-г дарс уухыг зөвшөөрсөн, дарсыг "адисласан" гэж боддог. Тэр хэзээ ч архи, дарсыг адислаагүй. Усны амтыг л усан үзэмнийх болгон өөрчилсөн. Нэг өдөр би нэг хүнтэй уулзсан, та бүхний мэдэх Романа Баталья гэдэг хүн. Тэр надаас, намайг Оюуны ухамсартай болгож өгөөч гэсэн Би зөвшөөрч, түүнийг ус аваад ир гэв. Тэр ус авчирч өгөхөд би өөрийн хууруунуудыг дүрсэн тэгээд тэр хүн усыг амталж үзээд "Эх минь, энэ дарс шиг юм" гэсэн Би "Тиймээ. Энэ байгаа юм. Яг үүнийг Христ хийсэн" гэсэн. Тиймээс, архи уухыг хэн ч адислаагүй. Тийм зүйлийг Христ хийнэ гэж яаж бодоо вэ? тийм оюун ухааныг чинь бүрэлгэх тийм зүйлийг Архи уудаг хүмүүс бол эрүүл биш хүмүүс тархиндаа ямар нэгэн асуудалтай болдог Жолоо барьж байхдаа асуудал үүсгэдэг, хүнтэй ярьж байгаа нь хүртэл анзаарвал зүгээр биш. Тэд маш түрэмгий, заримдаа маш идэвхгүй Ихэнхдээ тэд маш түрэмгий бөгөөд биеэ авч явж байгаа нь, хүнд зохисгүй авиртай болсон байдаг. Тиймээс, бид ойлгох хэрэгтэй, энэ дарс гэх маш их удаан хугацаанд исэлдүүлж гаргадаг зүйл нь маш буруу, бидний оюуны/сүнсний амьдралд маш хөнөөлтэй. (Мэдрэлийн эдэс үхэж нарийн оюуны мэдрэмжгүй, оюуны хомсдолд ордог). Архи дарсыг бүх нийтээр уух ёстой хэмээн хүлээн зөвшөөрсөн улс бүр зүгээр л нохойн хөгжил рүүгээ унаж байна. Энэ нь Шри Ганешийн эсрэг юм. Гэмгүй чанарын эсрэг Архи уудаг хүн маш башир, овжин, түрэмгий, төрөл бүрийн муу

авиртай болдог. Тийм архи уудаг хүнд хүн итгэх боломжгүй. Эхнэр, хүүхдүүд рүүгээ мөн хүн бүр рүү дайрдаг. тэдний амьдралыг сүйрүүлэхийг хүсдэг учир нь өөрийн сүйрэл нь ирч буйг мэддэг (далд ухамсартаа) Нэг зүйлийг ойлгох хэрэгтэй, гэмгүй чанар нь хэзээ ч хүний оюун ухамсрыг сүйрүүлдэг тийм зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй. Хүний оюун ухаан маш чухал. Үүнийг эрхэмлэн дээдлэх хэрэгтэй Таны оюун санааг муутгадаг, эрүүл мэндийг муутгадаг зүйлс бүгд буруу. Ялангуяа Сахажа йогчдод. Та бүхэн өөрсдийгөө эрүүл байлгах ёстой. Эрүүл мэндээ яаж хадгалах вэ гэвэл эрүүл мэндийг чинь устгаж буй, хөнөөлтэй зүйлсээс зайлсхийх Тэгэхлээр, гэрлэсэн гэр бүлийн амьдрал хайраар адислагддаг амьдрал нь ерөөгддөг. Ерөнхийдөө сүмд хийгддэг, гэхдээ Сахажа йогт, бүгд надаар ерөөгддөг Тиймээс ойлгох хэрэгтэй, энэ бол та бүхний хүртсэн –маш агуу зүйл юм. Гэхдээ зарим нэг тойруу явдаг хүмүүс байдаг "Эх минь, бид салмаар байна, бид сайн гэр бүлтэй болохыг хичээж байна", гээд төрөл бүрийн явдлууд ярьдаг. Мэдэж байна уу? Энэ гэрлэлт нь хэрвээ адислагдан сахажа йогийн бүх ёс горим, зан үйлээр явагдсан бол энд ямар ч муу зүйл байх боломжгүй. Харин, та өөрөө муу хүн бол, хэн ч танд туслах боломжгүй. Буруу бодлуудтай байвал засахыг хичээх хэрэгтэй. Сахажа йогт гэрлэхийг хүсч байвал гэр бүлийн амьдралын дархан ариун адисыг хүндлэхийг хичээ. Би мэднэ, заримдаа бүсгүйчүүд, заримдаа эрчүүд муу байдаг, асуудал үүсгэдэг. Гэхдээ ухаантай хүн бол, бүх зүйлсийг тэсч, даван гарахыг хичээдэг, яагаад гэвэл гэр бүлийн ариун дархныг хадгалахыг хүсдэг. Нэг зүйл хүмүүст маш ойлгомжгүй, маш зөрчилдөөнтэй байдаг. Христос нь гэр бүлийн ёслолоос гадуур төрсөн гэдэг нь мөн Шри Ганеша нь гэр бүлээс гадуур төрсөн. Тэдгээр нь, өөрсдөө нүгэлгүй ариуны, онгон дарханы ерөөл юм. Тэдэнд адислал/ерөөл хэрэггүй (гаднаас) Тэд гэмгүй ариун чанарын төлөөлөл юм, тийм хүмүүст тэдэнд, тийм зан үйл, ёслол, горим хэрэггүй байдаг. Тийм төрсөн юм, тийм туйлын ариун, гэм нүгэлгүй Гэхдээ бид тэднийг жишээ болгон дууриах зүйл биш. Тэд Бурхад байсан, мөн тэгж төрөх ёстой байсан, харин бид адислуулж ариун явдлыг амьдралдаа чандлан мөрдөх ёстой юм. Энэ бол Бурхан хүмүүс хоорондын ялгаатай байдал. Бурхныг (хувилгааныг) шүүмжлэх нь маш хялбар, амархан. Бүх Бурхны хувилгаануудыг хүмүүс дүгнэн шүүмжилдэг. Яагаад гэвэл хүмүүс тэднийг ойлгох чадваргүй учир. Гэхдээ, маш ариун, гэмгүй цайлган болохыг хичээ тэгвэл тэднийг ойлгож, яагаад тэдний амьдрал өөр түвшинд байсныг ойлгох болно. Хэрвээ одоо:"Эх минь, би ариун гэмгүй боллоо", гэлээ ч энэ боломжгүй Ямар аргаар гэмгүй ариун болох вэ? Сахажа йогт гэмгүй/ариун болох арга байдаг. Үүнд бид "бодлоос ангид" оюунаар хүрдэг. Хэрвээ та "бодлоос ангид" түвшинд байвал, юу болох вэ? Та хариу үйлдэхгүй, реакц үзүүлэхгүй, Буруу зүйлсэд орооцолдохгүй, автахгүй. Маргалдаанд, учир нотолгоонд орооцолдохгүй. Харин зүгээр л харах болно. Тэгээд дотроос чинь гэмгүй ариун чанар бохир намгаас өгсөн гардаг лянхуа мэт үзэсгэлэнтэйгээр нээгдэнэ. Нөхцөл байдал ямар ч байлаа бодлоос ангид оюунд байвад, та хариу үйлдэл (реакц) үзүүлэхгүй. Энэ бол ариун чанарын илрэл, тэмдэг юм. Тэгээд хариу үйлдэл (реакц) үзүүлдэггүй хүмүүс ямагт залуу байдаг. Тэдний нас нь хэзээ ч мэдэгдэдгүй, маш залуу харагддаг, учир нь хариу үйлдэл (реакц) үзүүлэх нь сайн зүйлд тооцогдохгүй энэ нь таныг бусад хүмүүсд хэт автах байдалд оруулдаг. Харин хэрвээ та реакц үзүүлэхгүй, зүгээр л гаднаас нь хараад, гэрчийн түвшинд байвал, та юунд ч автахгүй. Юмнаас ангид болно. Ийм маягаар таны гэмгүй ариун чанар хөгжинө мөн та өөртөө маш итгэлтэй, тайван болно. Би нэг Хятадын хаан гэгээнтэн хүн дээр очсон тухай өгүүлэл уншсан тэгээд түүнээс буян гуйхаар ирсэн гэж, "Ямар буян?" гэхэд, "Би хүүгээ төлөвшиж, бүх зүйлийг нүүрлэх чадвартай болгомоор байна, хүмүүс юу ч хийлээ, тэднийг нүүрлэх чадвартай болгомоор байна", гэж. Гэгээнтэн: "за, тэгж болно. Хүүгээ үлдээчих", гэв. Тэгээд, маргаан болж тэмцэлдээн болоход ханхүү маш номхон цэгцтэй зогсон, бүх зүйлийг бодолгүйн түвшинд харж байв. Тэгээд бүх маргаан үүсгэгч хүмүүс буцаад намдан, бүгд яваад өгөв. Тэд хүүгийн тэр гэмгүй агуу чанарыг тэсэхгүй байв. Хүү нь гэтэл маш залуухан. Хаан тэгээд гайхан бахархав, хэрхэн хүү нь тэдгээр бүх хүмүүсд, бүх хэл ам бүх түрэмгийлэл, түүнд хэлсэн бүх төрлийн аймшигтай зүйлсийг өнгөрөөхийг харав. Хэрвээ хүн танд ямар нэгэн зүйл хэлвэл, зүгээр л гэмгүй цайлган бай. Тэр үед таны гэмгүй чанарын хүч таныг дарамталж, зовоохыг завдаж байгаа тэр хүн маш буруу гэдгийг шууд харуулах болно. Нөгөө хүн ч магадгүй өөрийн буруу зүйл хийж байгаагаа ухаарч, намайг дарамтлах гэсэн чинь энэ хүн ямар ч ажигласан шинжгүй байх юм, гээд тэр хүн өөртөө тун хүчгүй сул санагдах болно, дарангуйлах ямар ч хүчгүй гэдгээ мэдэх болно. Тэгэхлээр, энэ бодлоос ангид энэ зүйл нь Сахажа йогч бидэнд байдаг Бид тэр бодлоос ангид түвшинд орж болно. Өөрийн (реакц) хариу үйлдлээ багасгахыг хичээ. Ямар ч хариу бүү үйлд Хүмүүс, өөрсдийгөө "их юм"-д боддог учир, тэд реакц үзүүлдэг. Жишээлбэл, нэг хүн надаа хивс үзүүлсэн, би үүнийг хараад маш баяртай байсан, "Бүх сахажа йогч бүсгүйчүүд үүнийг гараар урласан, маш сайхан". Үнэхээр, үүнийг тэд хийсэн гэдгийг мэдэх баяртай сайхан санагдсан. Харин жишээ нь би өөр нэг энгийн хүн байсан бол, "Өө бурхан минь, ямар хачин өнгөтэй зүйл вэ", гэх мэт авир гаргах байсан. Тэгээд юу ч хийсэн байлаа би баярлахгүй байх байсан. Нэг гол зүйл нь, баяр нь гээгддэг. Хүүхдийн хувьд баярлах байдал нь бүрэн илэрдэг. Харсан юм болгондоо баярлаж, зүйлсийг баяртай болгож байдаг. Хүүхдүүдийг хараач дээ. Би хүүхдүүдийг харахад, тааралдсан зүйл болгоныг өөрсдийн тоглоом болгодог. Эртүүд бид Женова-н цамхаг руу явахад тэнд том модон тайрдаснууд байсан. Тэнд хэдэн

хүүхдүүд ирээд дээр нь авираад морь болгон тоглож, баяртай байсан. Тэд хаана ч байлаа, юуг ч харлаа бүх зүйлийг маш баяр баясаглантай тоглоом болгож байдаг. Хүүхдийн хувьд амьдрал хүртэл тоглоом. Зүгээр л баярлах нэг зүйл. Мөн бусдыг бүх зүйлд баярлуулж байдаг. Хэрвээ та нэг тийм сайхан биш ааштай байвал, хүрч ирээд хүүхдүүд ямар нэгэн байдлаар, ямар нэгэн зүйл үйлдэж эхэлдэг тэгээд хүнийг маш энгийн байдалд нь буцааж оруулдаг. Тэгээд, бид энгийн, хялбархан хүнийг хараад, тэд яг хүүхэд шиг юмаа гэдэг. Тийм хүмүүс, башир, хортой байхыг мэддэггүй. Хүмүүсийн ухаангүй, муйхар загнахыг ойлгодоггүй, өөрсдийн гэнэн ариун ертөнцдөө амьдардаг. Үүнтэй адил бүх сажаа йогчид энэхүү аураг өөртөө бүрдүүлэх ёстой

2002-1103, Diwali Puja, The Importance of Meditation (part)

[View online.](#)

Diwali Puja. Lake Piru, Los Angeles, (USA) - 3 November 2002.

Өдөр бүр та нар бясалгаж байх хэрэгтэй. Бясалгал хийдэггүй хүмүүс нь – доош унах – боломжтой. Яагаад гэвэл, Бясалгах нь бол дэнлүүнд тос хийхтэй адил юм. Бясалгал хийдэггүй хэд нь - “үүнэгүйгээр болчихно” гэж бодож байвал – харамсалтайгаар эндүүрч байна. Тэд өглөө мөн орой болгон бясалгаж байх хэрэгтэй. Асуудал нь бол: (Сахажа йогт) бүх юм бэлэн, гарын доор, маш энгийн хялбархан ирдэг учир тэд, бясалгах нь маш чухал гэдгийг ойлгохгүй байна. Магадгүй... Та нар биш л дээ, гэхдээ маш олон Оюунаа сэргээчихээд, бясалгалаа хийдэггүй хүмүүс байгааг би мэднэ. Тэгээд, тэдний байдал, хэв маяг нь өөр байдаг. Тэдний дотоод байдал нь өөр байдаг. Бясалгал бол үнэхээр тайтгаруулж, тэтгэгч зүйл... Гэгээн тэнгэртэй холбогдох үлэмжийн сайхан арга. Тэрхүү бясалгалын төлөвд байхад таны бүхий л асуудлууд шийдэгддэг. Хэрвээ та бясалгалаа хийдэггүй юм бол, хэрвээ та бясалгалаа мөрдөдгүй юм бол магадгүй таны гэрэл мөхөх байх. ...(олсон жаахан нь) хангалттай гэрэл өгч чадахгүй. Энэ бол чухал юм. Маш их чухал зүйл. Өөрийн талаар болон бусдын талаар бясалгалдаа олж харах нь маш чухал юм. “Яаж бясалгал хийх вэ?” гэж олон хүмүүс асуудаг. - Юу ч хийх хэрэггүй. Зүгээр л "бодол үгүй оюуны оршихуй"-д ор. "Бодлоос ангид ухамсрын түвшин"-рүү орохыг хичээ. Хэрвээ та тэрхүү бодол үгүй оюуны оршихуйд орж чадвал -та хийх ёстой зүйлээ хийсэн. Яагаад гэвэл энд та Үнэн, Бодит оршихуй, Баяр жаргал зэрэг бүхий л үндсэн чанар болсон чухал зүйлстэй нэгдэх тэр өртөг нь юм. Бясалгаж байхдаа үүнийгээ ямар нэгэн гүйцэтгэх үйлдэл болгохгүй байхыг хичээ. Бясалгал бол өөрийгөө намдааж, аниргүй болгох зүйл юм. Бодол санаагаа аниргүй болгох. Тэгээд өөр дотор чинь байгаа тэрхүү далай руу умбах арга юм Гэтэл, та нар үүнийг хийдэггүй байлаа гэж бодъё. бяслагадаггүй гэж бодъё... Надаа шууд л мэдэгддэг. Бясалгал хийдэг, бясалгал хийдэггүй хүмүүсийг би шууд л мэддэг. Үүнийг мэдэхэд надаа хэцүү биш. Бясалгал хийдэггүй хэд нь ямагт эргэлзэж тээнэгэлзсэн байдаг. Тэд төөрөлдсөн байдаг. (Нарийн) зүйлсийг ойлгодоггүй. Тийм учраас, Бясалгах нь бол Сахажа йоганд хамгийн чухал зүйл нь юм. Гэрэл нь цахилгаан гүйдлийн улмаас гэрэлтдэг шиг, эсвэл лаа нь тосны улмаас асдаг шиг, үүнтэй адил, Бясалгал бол - Тэнгэр/Бурхны хүчний тасралтгүй урсгал юм. Энэ нь таны аливаа (буруу) ойлголтыг өөрчлөнө, үүгээр барахгүй бүхий л муу бодлуудыг арилгана, аливаа урам хугалах зүйлийг арилгана. Тэгээд, та нар ийм маягаар бодлоос ангид оюун-д нь бясалгаад байвал, та нар дотроосоо ч, гаднаасаа ч хэрхэн дэмжигдсэнээ хараад гайхах болно, Энэ нь маш агуу их хүч юм, бодлоос ангид оюун нь Тэгэхлээр, бясалгалаа хийдэггүй хэд нь хол явж чадахгүй, Сахажа йогийн ашиг тусыг тэгж их хүртэж чадахгүй. Хүн бясалгахыг хичээж байх хэрэгтэй. Бодолгүй оюуны түвшинд хүрэх хэрэгтэй. Тэгвэл, танд юу болох (тохиолдох) вэ? Та бодол үгүй оюуны түвшинд байвал, танд танд юу болох вэ гэвэл, та өөртөө үнэмлэхүй итгэлтэй болно, Бурханлагийн талаарх бүрэн (мэдэж) итгэлтэй болно. Танд (тэр нь) байгаа гэдгийг та өөрөө мэдэх болно. Манай Дарамшала-гийн сургуулиас ирсэн хүүхдүүдийг би харсан. Тэд өөртөө туйлын их итгэлтэй, мөн туйлын их даруу төлөв байсан. Тэгээд би тэднээс: “та нар юу хийдэг вэ?” гэж асуухад, тэд: “Эх минь, бид бясалгадаг”, гэсэн. “Бид сургуульдаа, орой бөөнөөрөө бясалгадаг, тэгээд тэр бясалгал нь бидэнд тусалдаг”, гэсэн. Төсөөлөлдөө, ийм жаахан хүүхдүүд тийм юмыг хэлж байдаг, гэтэл та нар яагаад ойлгож болохгүй гэж? Бясалгал нь өөртөө итгэх итгэл, аюулгүйн мэдрэмжийг өгдөг. Энэ нь та нарт үнэнхүү гэгээрлийг өгнө. Мөн Бурхантай холбогдох үнэмлэхүй холбоог өгнө. Бурхантай холбоо үгүй бол Сахажа йогоор хичээллэх ямар хэрэг байна? Би мэднэ, бясалгалаа хийгээд, өөрсдийн гүн гүнзгийг хүрч маш их дэвшсэн хүмүүс байгаа, би мэднэ. Мөн бас, жаахан хуурмаг тийш явчихсан хүмүүсийг би мэднэ. Таны гүн гүнзгий – “Бодол үгүй оюуны ухамсарт” оршидог. Энэ бол таны хүрэх ёстой маш чухал өртөг юм. Та ямар нэгэн юмруу харахдаа (тухайн зүйлийг) бодол үгүй ухамсарлах юм бол та үнэхээр юмсыг ойлгож тусгадаг болно. Тийм маягаар л (юмс) ажилладаг. Би мэдэхгүй. Хэр удаан та тэрхүү байдалд байж чадахыг би мэдэхгүй. Гэхдээ хэрвээ 1 секунд ч гэсэн та үүнд хүрч чадвал, та үргэлжлүүлээд үүнд илүү их хүрж, олсоор байхыг хүсэх болно. Би бясалгалын талаар өмнө маш их ярьж байсан. Харин өнөөдөр би эдгээр асч буй лаануудыг хараад эдгээр нь бясалгаж байгаа юм биш үү, гэж бодно. Эдгээр нь бүгд бясалгалын байдалд байгаа учраас тэд ингэж асч байгаа юм. Үүнтэй адилхан, би бясалгадаг Сахажа йогчидыг мэднэ, мөн бясалгадаггүйг нь ч би мэднэ. Тэгээд тэдгээр нь асуудалтай байвал, яагаад асуудалтай байгааг нь би мөн мэднэ. Хамгийн гол зүйл нь бол - таны Бурхантай нэгдэх холбоо. Тэгээд үүнд та зөвхөн - бясалгаад, “бодол үгүй ухамсартай” болвол л хүрнэ. Энэ бол тэрхүү Тэнгэр/Бурхны үйлддэг, тусалдаг (эхний) өртөг юм. “Энэ нь” танд туслахдаа, та “үүнд яаж хүрсэн юм болоо” гэмээр юу ч мэдэгдэлгүйгээр үйлддэг. Тэгэхлээр, бодол үгүй оюун бол (ухамсар) та нарын хүрэх ёстой эхний өртөг юм. Маш

чухал. Үүний дараата та ямар нэг өөр юманд хүрж болно, харин энхний шат бол – бодол үгүй ухамсрын түвшин юм. Энэ бол маш чухал. Бодлоос ангид оюунтай болох нь, (ухамсарладаг болох нь) чухал. Яагаад гэвэл тэр үед танд ямар ч бодол, зүүн баруун талаас, өнгөрсөн болон ирээдүйгээс гарч ирж танд садаа болохгүй. Зөвхөн л одоо цагтаа, бодит байна. Энэ нь та бүхэнд бүгдэнд нь байдаг, миний хэлсэн болохоор биш. Энэ нь та бүхэнд бүгдэнд нь байдаг. Гэхдээ үүнийгээ тогтоож бататга. Та бүхэн өөрсдийгөө бодол үгүй оюуны ухамсарт тогтворжуулах хэрэгтэй. Хэр удаан нь энд хамаагүй. Харин, хэрвээ та ганц удаа ч үүнд нь хүрвэл та үргэлжлүүлээд үүнд нь хүрдэг болно. Маш олон хүмүүс бясалгадаг, гэхдээ тэдний бодлын үйл явц нь зогсоогүй байдаг. Тэд бодлоос ангид аниргүйн түвшинд ороогүй байдаг. Энэ бол тэрхүү маш чухал, онцлох өртөө нь юм. Хэрвээ та өсөж дэвшье л гэж бодож байвал та Бурхантай үнэмлэхүй холбоотой байх хэрэгтэй, бодол үгүй оюун, ухамсрын түвшинд. Хэн нэгнийг дуудах хэрэггүй, ямар ч тийм юм үгүй. Энэ нь зүгээр л үйлдэж эхэлдэг, яагаад гэвэл энэ нь дотор чинь байгаа учир. Эдгээр энэ бүх бодлууд хоёр талаас чинь бөмбөгдөж байдаг. Толгойнд чинь. Тань руу ирж байгаа эдгээр бүх бодлууд ямар ч утга агуулаггүй. Таныг бодитой болгохгүй. Та өөрөө бол далай мэт юм. Та нар өөсдөө тэрхүү бодол үгүй ухамсрын түвшинд хүрч гарах хэрэгтэй. Энэ талаар, бүх агуу судруудад, ямагт бичигдсэн байдаг, гэхдээ миний хэлж байгаа шиг ийм тодорхой ойлгомжтой биш. Та бүхний зарим нэг нь бодол үгүй ухамсрын түвшинд хүрээгүй гээд би "хэнд ч хэрэггүй хүн" гэж хэлэх гээгүй юм. Үгүй. Гэхдээ оролдоод үз. Та нар бүгд тэр "бодлоос ангид" түвшинд хүрч чадна. Нэг секунд ч гэсэн хүрч чадвал энэ нь маш сайн хэрэг юм. Тэгвэл та тэрхүү секундээ уртасгасаар байх болно. Би үүнийг хариу тусгалтай бодол гэнэ. Нэг зүйл рүү харахдаа, бодолгүй ухамсарлаж байвал таны бодлууд тусгадаг, харж байгаа юмныхаа гүн гүнзгийг тусгадаг. Ийм маягаар, та бүхэн бүгд үнэхээр маш бүтээлч сахажа йогчид болж хувирна. Би юуг анзаарсан бэ гэвэл, энэ бодлоос ангид ухамсрын түвшинд олон хүн тогтворжоогүй байна. Энэ нь сайн биш юм. Өнөөдөр, энэ Дивали (гэрлийн) өдөр би та бүхнээс өөрсдийгөө энэ бодлоос ангид түвшинд гэгээрүүл гэж хэлмээр байна. Энэ хэцүү биш, дотор чинь байдаг. Бодлууд энэ тал, тэр талаас гарч ирээд байдаг учир... Тэгээд эдгээр нь таны тархины хөдөлгөөн биш, огт үгүй. Зүгээр л таны хариу үйлдэл байгаа юм. Харин та үнэн утгаар нь бясалгаж байвал тэр бодлоос ангид ухамсрын түвшинд нь хүрнэ. Энэ нь маш чухал өртөг юм. Тэгээд танд ямар ч хэрэггүй эдгээр бүх утгагүй бодлууд алга болно. Алга болно, тэгээд таны өсөлт дэвшил боломжтой болно. Энд байгаа олон хүмүүс: "Эх минь, би тэр түвшинд орохгүй байна", гэх байх. Гэхдээ үз. Үзээд бай. Та нар чадахгүй, үүнд хүрэхгүй гэдэгт би итгэхгүй. Та бүхэн бүгд: "Би чадна" гэсэн бодолтой байх хэрэгтэй. Үүнд та бүхэн хүрнэ. Үүний тулд, та зүйлсийг үгүйсгэх хэрэггүй, Зүгээр л бясалгалдаа ор эсвэл ямар нэг (хэцүү) зүйлийг үзэх хэрэггүй, зүгээр л... бясалгалдаа ор. Тэгээд та гайхна, хэрхэн зүйлсүүд боловсорч, шийдэгдэхийг хараад гайхна. Мэдээж хэрэг, та бүхний ихэнх нь тэр оршихуйд маш их орсон байгаа, гэлээ ч би, тэр бодлоос ангид оюуны ухамсрыг нэмэгдүүл гэж хэлмээр байна. Тэр оршихуйн оронг нэмэгдүүл.